

БОЛОВСРОЛЫН ЯАМ

**НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАЛЦАГЧИЙН
СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАГШИЙН ЗӨВЛӨМЖ**

Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн багшид зориулав

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА	
НЭГ. ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЛЭХ НЬ	4
Зорилго	4
Сургуульд дасан зохицох үйл ажиллагааг ойлгох нь	4
Жишиг төлөвлөлтийг ашиглах нь	4
Арга зүй	4
“Би сурагч боллоо I” сурагчийн дэвтрийг ашиглах нь	6
Дасан зохицох явцыг ажиглаж, дэмжих нь	7
Орчин, хэрэглэгдэхүүн ба аюулгүй байдал	7
Зөвлөмжид хэрэглэсэн тэмдэг, тэмдэглэгээ	7
ХОЁР. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИШИГ ТӨЛӨВЛӨЛТ	8
I ДОЛОО ХОНОГ. МАНАЙ СУРГУУЛЬ	8
СЭДЭВ 1. МИНИЙ СУРГУУЛЬ	8
СЭДЭВ 2. БИ ХЭНЭЭС ТУСЛАМЖ ХҮСЭХ ВЭ?	13
СЭДЭВ 3. МАНАЙ АНГИ	16
СЭДЭВ 4. БИ СУРГУУЛЬДАА ИРЛЭЭ	21
СЭДЭВ 5. СУРГУУЛИЙН НЭГ ӨДӨР	27
II ДОЛОО ХОНОГ. БИД НЭГ АНГИЙНХАН	31
СЭДЭВ 6. НАЙЗУУДТАЙГАА ТАНИЛЦЪЯ	31
СЭДЭВ 7. СОНСЪЁ, ЭЭЛЖЭЭ ХҮЛЭЭ	34
СЭДЭВ 8. БИДНИЙ ДҮРЭМ	41
СЭДЭВ 9. ТУСАЛЪЯ, ТАЛАРХЪЯ	46
СЭДЭВ 10. БИД ХАМТДАА ХИЙЖ ЧАДНА	52
III ДОЛОО ХОНОГ. БИ СУРГУУЛИЙН СУРАГЧ	59
СЭДЭВ: 11. МИНИЙ ЦҮНХ	59
СЭДЭВ 12. СОНСООД ДАРААЛЛААР НЬ ХИЙЕ	67
СЭДЭВ 13. ӨНӨӨДӨР ЮУ ХИЙХ ВЭ?	75
СЭДЭВ 14. АШИГЛАЯ, ХУРААЯ	80
СЭДЭВ 15. АЖИГЛАЯ, АНГИЛЪЯ, ТООЛЪЁ, ТОГЛОЁ	89

БАГШ ТАНАА

Нэгдүгээр ангид элсэх нь хүүхдийн амьдралын шинэ, онцгой үе юм. Гэр бүл болон сургуулийн өмнөх боловсролын танил орчноос сургууль хэмээх шинэ орчин, шинэ хүмүүс, шинэ харилцаа, өдөр тутмын шинэ дэг, суралцах үйл ажиллагаанд шилжих энэ үед суралцагч бүр өөрийн хэмнэлээр танилцаж, туршиж, оролцож, аажмаар дадлагажна.

Энэ шилжилтийг хүүхдэд тайван, эерэг, итгэлтэй даван туулахад багшийн харилцаа, үлгэрлэл, тогтвортой дэмжлэг хамгийн чухал. Суралцагчийг богино хугацаанд ижил түвшинд хүргэхээс илүүтэй сургуульдаа ирэхдээ тайван байх, орчноо таних, бусадтай харилцах, тусламж хүсэх, өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох, “би энд байж чадна, би суралцаж чадна” гэсэн итгэлтэй болоход нь дэмжихийг эрхэмлээрэй.

Энэхүү зөвлөмж нь сургуульд дасан зохицох үйл ажиллагааг өдөр тутмын хичээл, завсарлагаа, үдийн хоол, сургуульд ирэх, тарах болон бусад бодит үйлтэй уялдуулан зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой. Зөвлөмжид санал болгосон үйл ажиллагаа, асуулт, хэрэглэгдэхүүнийг суралцагчийн хэрэгцээ, сургуулийн орчин, цагийн хуваарь, бодит нөхцөлд нийцүүлэн хувиргаж хэрэглээрэй.

Суралцагчийн хийж чадсан жижиг гэлтгүй ахиц, амжилтыг өдөр бүр анзаарч, дэмжиж, дахин оролдох боломж олгоорой. Өнөөдөр зөвхөн ажиглаж байсан суралцагч маргааш туршиж, өнөөдөр бусдын тусламжтай хийж байсан бол хэд хоногийн дараа бие даан гүйцэтгэж чадна. Дасан зохицох үйл явцын үнэ цэн нь хүүхэд бүр сургуулийн амьдралд өөрийн хэмнэлээр, итгэлтэйгээр оролцож эхлэхэд оршино.

Суралцагчийн өдөр тутмын оролцоо, ахиц, хэрэгцээг анхааралтай ажиглаж, шаардлагатай дэмжлэгийг I улирал болон цаашдын сургалтын явцад үргэлжлүүлээрэй.

Таны өдөр тутмын эерэг харилцаа, ойлгомжтой чиглүүлэг, тэвчээртэй дэмжлэг хүүхэд бүрд сургуулийг “миний байх газар”, суралцахыг “миний хийж чадах зүйл” болгон мэдрэх эхлэл болно.

НЭГ. ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЛЭХ НЬ

Зорилго

Энэхүү зөвлөмж нь нэгдүгээр ангид шинээр элсэн суралцаж буй суралцагчийг сургуулийн орчин, харилцаа, өдөр тутмын дэг, бие даах болон суралцах үйл ажиллагаанд аажмаар оролцоход дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг багш өдөр тутмын сургалт, үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой.

Зөвлөмжид хичээлийн жилийн эхний дөрвөн долоо хоногийн 20 өдрийн жишиг төлөвлөлтийг хэрэгжүүлэх, сурагчийн дэвтрийг ашиглах арга, ялгаатай хэрэгцээ, түүнд үндэслэн тохируулга хийх, ажиглалт ба дэмжлэг, орчин ба хэрэглэгдэхүүний бэлтгэл болон сэдэв бүрийн сургалтын хөтөлбөртэй уялдах боломжийг тусгав.

Сургуульд дасан зохицох үйл ажиллагааг ойлгох нь

Нэгдүгээр ангийн суралцагчийн сургуульд дасан зохицох үйл ажиллагааг хичээлийн жилийн эхний дөрвөн долоо хоногт зохион байгуулна. Гэвч энэ хугацааг суралцагч бүр сургууль, шинэ орчиндоо бүрэн дасан зохицож, цаашдын суралцах үйл ажиллагаанд ижил түвшинд бэлтгэгдсэн байх хугацаа, шалгуур гэж ойлгохгүй. Суралцагч бүрийн өмнөх туршлага, хөгжлийн онцлог, хэл, харилцаа, суралцах хэмнэл, бие даах байдал болон дэмжлэгийн хэрэгцээ харилцан адилгүй тул дасан зохицох явц нь мөн өөр өөр хугацаа, хэмнэлтэй байна. Иймээс шаардлагатай дэмжлэг, тохируулгыг I улирал болон цаашдын сургалтын явцад үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Дасан зохицох үйл ажиллагаа нь хичээл, завсарлага, үдийн хоол, сургуульд ирэх, тарах болон өдөр тутмын бусад бодит үйл ажиллагааг харилцан уялдаатайгаар төлөвлөж, хэрэгжүүлэх нэгдмэл, цогц үйл ажиллагаа юм.

Суралцагч сургуулийн орчин, хүмүүс, өдөр тутмын дэг, хэрэглэгдэхүүн, харилцааг бодитоор ажиглах, хийж турших, давтан хэрэглэх, бусадтай хамтран оролцох, хуваалцах, ярилцах боломж бүрдүүлнэ. Ингэснээр суралцагч шинэ орчин, шинэ харилцааг аажмаар ойлгож, өдөр тутмын үйл ажиллагаанд өөртөө итгэлтэйгээр оролцох суурь бүрдэнэ.

Багшийн хувьд суралцагчийг “хурдан дасгах”-аас илүү тайван, аюулгүй орчинд өөрийн хэмнэлээр оролцох, тусламж хүсэх, турших, алдаж дахин оролдох, аажмаар бие даах боломжийг бүрдүүлэх нь дасан зохицох үйл ажиллагааны гол мөн чанар юм.

Жишиг төлөвлөлтийг ашиглах нь

Жишиг төлөвлөлт нь хичээлийн жилийн эхний дөрвөн долоо хоногийн сэдэв, зорилго, үйл ажиллагааны залгамж холбоог бүхэлд нь харах баримжаа болно. Өдөр тутмын дэлгэрэнгүй зөвлөмжийг тухайн өдрийн үйл ажиллагааг зохион байгуулахдаа ашиглана.

Төлөвлөлтийг шууд хэрэгжүүлэх бус тухайн өдрийн зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хадгалан, сургуулийн орчин, цагийн хуваарь, анги дүүргэлт, суралцагчдын хэрэгцээ, ашиглах боломжтой хэрэглэгдэхүүнд нийцүүлэн хувиргаж, хэрэглэнэ.

Тухайн өдрийн зорилгыг суралцагч бүр тэр өдөртөө бүрэн биелүүлэх ёстой шалгуур гэж үзэхгүй. Нэг суралцагч үйлдлийг ажиглаж танилцаж байхад нөгөө нь бусдын дэмжлэгтэйгээр туршиж, өөр нэг суралцагч бие даан гүйцэтгэж байж болно. Өнөөдөр хийсэн үйлээ дараагийн өдөр, хичээл, завсарлага, үдийн хоол болон бусад бодит нөхцөлд давтан хэрэглэх боломж бүрдүүлнэ.

Арга зүй

Сургуульд дасан зохицох үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ суралцагчийн нас, хөгжлийн онцлог, өмнөх туршлага, ялгаатай хэрэгцээг харгалзан бодит үйл ажиллагаа, тоглоом, хөдөлгөөн, ажиглалт, ярилцлага, хамтын оролцоонд тулгуурлана. Багш суралцагчийг танилаас шинэ рүү, бусдын дэмжлэгтэй үйл ажиллагаанаас бие даан гүйцэтгэхэд аажмаар шилжүүлж, өдөр тутмын бодит нөхцөлд давтан турших, алдаа гаргах, дахин оролдох, өөрийн хэмнэлээр ахих боломжийг бүрдүүлнэ. Үйл ажиллагааны явцад суралцагчийн

оролцоо, хэрэгцээг ажиглаж, заавар, хугацаа, орчин, хэрэглэгдэхүүн болон оролцооны хэлбэрийг тохируулан хэрэглэнэ.

Дасан зохицох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхдээ дараах арга зүйн чиглэлийг баримтална. Үүнд:

1. Бодит үйл ажиллагаанд тулгуурлана.

Сургуулийн орчинд бодитоор гүйцэтгэж болох үйлийг зураг, тайлбар, ажлын хуудсаар хязгаарлахгүй. Анги, ариун цэврийн өрөө, цайны газар, орох/гарах хэсгийг тэмдэглэгээ ашиглан олох, гараа угаах, ээлжээ хүлээх, тусламж хүсэх, хэрэглэгдэхүүнээ авах, ашиглах, хураах зэрэг үйлийг бодит нөхцөлд хийж турших, давтан хэрэгжүүлэх боломж бүрдүүлнэ. Зураг, карт, сурагчийн дэвтрийг бодит туршлагыг дэмжих, эргэн санах, бататгах хэрэглэгдэхүүн болгон ашиглана.

2. Дэмжлэгтэй үйл ажиллагаанаас бие даан гүйцэтгэхэд аажмаар шилжүүлнэ.

Шинэ үйлийг эхлээд ажиглуулах, шаардлагатай үед багш загварчлан үзүүлэх, хамтран хийж турших, давтан оролдох боломж олгоно. Суралцагчийн оролцоо тогтворжихын хэрээр дэмжлэгийг аажмаар багасгаж, өөрөө сонгох, эхлүүлэх, гүйцэтгэх, дуусгах боломжийг нэмэгдүүлнэ.

3. Зааврыг богино, тодорхой, хэрэгжүүлэхэд хялбар байдлаар өгнө.

Нэг дор олон үйлдэл хийхийг шаардахгүй. Шаардлагатай үед зааврыг 1–2 алхам болгон хувааж, зурагт карт, таних тэмдэг, бодит хэрэглэгдэхүүнээр дэмжинэ. Заавар өгсний дараа суралцагчид ойлгох, ажиглах, гүйцэтгэх хангалттай хугацаа олгоно.

4. Өдөр тутмын давтагдах үйлийг тогтвортой дадал болгон дэмжинэ.

Мэндлэх, эд зүйлээ бэлтгэх, гараа угаах, ээлжээ хүлээх, тусламж хүсэх, хэрэглэснээ хураах, орчноо цэгцлэх зэрэг үйлийг нэг удаагийн даалгавар гэж үзэхгүй. Тэмдэглэгээ, зурагт хуваарь, дэг, сануулгыг тогтмол хэрэглэж, бодит нөхцөлд өдөр бүр давтан хэрэгжүүлэх замаар аажмаар хэвшүүлнэ.

5. Сэтгэл зүйн хувьд аюулгүй орчин бүрдүүлнэ.

Суралцагчийн мэдрэмж, үзэл бодол, асуулт, сонголтыг хүндэтгэж, алдаа гаргах, дахин оролдох тусламж хүсэх боломж олгоно. Суралцагчийг бусадтай харьцуулах, ичээх, айлгах, ялгамжтай харьцахаас зайлсхийж, бие даах оролдлого, ахиц бүрийг дэмжинэ.

6. Оролцох, өөрийгөө илэрхийлэх олон хэлбэрийг хүлээн зөвшөөрнө.

Суралцагч бүр санаа, мэдрэмж, хэрэгцээгээ ижил аргаар илэрхийлэх албагүй. Ярих, нэг үг эсхүл богино хэллэг хэрэглэх, зураг заах, сонгох, дохио, хөдөлгөөн, зурах зэрэг өөрт тохирох хэлбэрээр оролцох боломж олгоно. Шаардлагатай үед сонголтын тоо, даалгаврын хэмжээ, хугацаа, хэрэглэгдэхүүн болон оролцооны хэлбэрт тохируулга хийнэ.

7. Хос, жижиг бүлгийн оролцоог аажмаар нэмэгдүүлнэ.

Нийт ангийн өмнө шууд ярих, том бүлгээр ажиллахыг шаардахаас өмнө хосоор, дараа нь 3–4 суралцагчтай жижиг бүлгээр ажиллах боломж бүрдүүлнэ. Хамтын үйл ажиллагаанд суралцагч бүр ойлгомжтой, хийж чадахуйц үүрэгтэй байж, бусдыг сонсох, ээлжээ хүлээх, туслах, хамтран дуусгах туршлага хуримтлуулахад чиглүүлнэ.

8. Ажиглалтад тулгуурлан дэмжлэгээ тохируулна.

Үйл ажиллагааны явцад суралцагч юу хийж чадаж байгаа, хаана дэмжлэг шаардлагатай байгааг ажиглаж, заавар, хугацаа, орчин, хэрэглэгдэхүүн болон оролцооны хэлбэрийг тохируулна. Ажиглалтын зорилго нь суралцагчийг үнэлж, харьцуулахад бус дараагийн дэмжлэгийг оновчтой төлөвлөхөд оршино.

9. Сургалтын хөтөлбөрт туссан чадвар, чадамжийг үйл ажиллагаагаар дамжуулан дэмжинэ.

Дасан зохицох үйл ажиллагааны явцад сургалтын хөтөлбөрт туссан сонсох, ярих, ажиглах, тоолох, ангилах, байрлал, дарааллыг баримжаалах, сонголт хийх, хамтран ажиллах зэрэг чадвар болон харилцах, шүүн тунгаах, суралцахууд суралцах, нийгэм-сэтгэл хөдлөлийн чадамжийг бодит нөхцөлд хэрэглэх боломж бүрдүүлнэ. Эдгээрийг тухайн өдрийн суралцахуйн үр дүн болгон шууд эзэмшүүлэхийг зорихгүй, дасан зохицох үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлнэ.

“Би сурагч боллоо I” сурагчийн дэвтрийг ашиглах нь

“Би сурагч боллоо I” сурагчийн дэвтэр нь суралцагч ажигласан, хийж туршсан, ярилцсан зүйлээ эргэн санах, илэрхийлэх, бататгах хэрэглэгдэхүүн юм.

Дэвтрийн гарчиг, зааврыг багш, эцэг эх, асран хамгаалагч уншиж, суралцагчийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан тайлбарлана. Сонгох, холбох, зурах, будах, сонсох, ярилцах, хайчлах, наах зэрэг үйлийг тухайн өдрийн бодит үйл ажиллагаатай холбоно. Дэвтэрт дүрслэгдсэн сургууль, анги, өрөө тасалгаа, хүн, хэрэглэгдэхүүн нь тухайн сургуулийн бодит орчинтой заавал ижил байх албагүй. Иймд зурагт мэдээллийг “Манай сургуульд энэ хаана байдаг вэ?”, “Манай ангид үүнтэй адил зүйл байна уу?”, “Бид үүнийг яаж хийдэг вэ?” гэх мэт асуултаар бодит орчин, өдөр тутмын туршлагатай нь холбон ярилцана.

Суралцагчийн дэвтэрт ажилласан байдлыг “зөв, буруу”, “сайн, муу” гэж үнэлэхээс илүүтэй тухайн үйл ажиллагаанд оролцсон байдал, ажигласан зүйлээ таньсан эсэх, сонголтоо илэрхийлсэн байдал, өмнөх туршлагаа эргэн санаж чадсан эсэхэд анхаарна.

Ялгаатай хэрэгцээнд тохируулга хийх нь

Суралцагч бүрийн өмнөх туршлага, хөгжлийн онцлог, суралцах хэмнэл, харилцах болон оролцох арга хэлбэр харилцан адилгүй. Иймээс бүх суралцагч ижил хугацаанд, ижил арга, ижил дэмжлэгтэйгээр хичээл, үйл ажиллагаанд оролцох боломжгүй. Харин тухайн үйл ажиллагаанд оролцоход ямар хүндрэл учирч байгааг ажиглаж, заавар, хугацаа, орчин, хэрэглэгдэхүүн, үйл ажиллагааны алхам болон хариу илэрхийлэх хэлбэрт тохирсон дэмжлэг үзүүлнэ.

Тохируулга хийхдээ суралцагчийн хийж чадах зүйл, сонирхол, давуу талд тулгуурлан оролцох боломжийг нэмэгдүүлэхэд анхаарна. Тохируулга нь үйл ажиллагааны зорилгыг өөрчлөх бус, тухайн зорилгод хүрэхэд суралцагчид тулгарч буй саадыг багасгах арга юм.

Ажиглагдаж болох бэрхшээл	Багшийн үзүүлж болох дэмжлэгийн жишээ
Суралцагч урт, олон алхамтай зааврыг биелүүлэхэд хүндрэлтэй байх	Зааврыг богиносгож, нэг удаад нэг л үйлдэл хийлгэх; зураг, бодит зүйл, хөдөлгөөний загвараар үзүүлэх.
Суралцагч олон сонголтоос сонголт хийж чадахгүй байх	Сонголтын тоог цөөлж, эхний ээлжид хоёр тодорхой сонголт санал болгох.
Суралцагч өөрийн бодол, санаа, хариултаа яриагаар илэрхийлэхэд хүндрэлтэй байх	Зураг заах, сонгох, дохио, хөдөлгөөн, нэг үг эсхүл богино хэллэгээр хариулах боломж олгох.
Шинэ орчин, шинэ үйл ажиллагаанд оролцоходоо түгшиж, эргэлзэж байвал	Орчин, үйл ажиллагааны дарааллыг урьдчилан танилцуулах; багш эсхүл танил найзтай нь хамт оролцуулах; тайвшрах хугацаа олгох.
Үйл ажиллагааг гүйцэтгэхэд илүү хугацаа шаардлагатай	Гүйцэтгэх хугацааг нэмэгдүүлэх; даалгаврыг жижиг алхамд хуваах; шаардлагагүй алхмыг цөөлөх.
Анхаарлаа удаан төвлөрүүлэхэд хүндрэлтэй	Үйл ажиллагааг богино хэсгээр зохион байгуулах; нэг удаад хэрэглэх материалыг цөөлөх; хөдөлгөөнтэй богино завсарлага оруулах.

Бүлгийн үйл ажиллагаанд шууд оролцоход хүндрэлтэй	Эхлээд багштай эсхүл хосоор ажиллуулах, дараа нь жижиг бүлэгт аажмаар оролцуулах.
Дуу чимээ, олон хүн, орчны өдөөлтөд мэдрэмтгий байвал	Боломжтой бол нам гүм байрлал сонгох; шаардлагагүй дуу, харааны өдөөлтийг багасгах; үйл ажиллагаанд дасах нэмэлт хугацаа олгох.

Дасан зохицох явцыг ажиглаж, дэмжих нь

Дасан зохицох явцыг тусгай шалгалт, оноо, эрэмбээр үнэлэхгүй. Суралцагч өдөр тутмын бодит нөхцөлд хэрхэн оролцож байгаа, ямар үйлийг бие даан хийж эхэлсэн, хаана сануулга, загвар, нэмэлт хугацаа эсхүл өөр төрлийн дэмжлэг шаардлагатай байгааг ажиглана.

Нэг өдөр бүх суралцагчийн бүх үйлийг зэрэг ажиглах шаардлагагүй. Тухайн өдрийн зорилготой холбоотой 1–2 үйлийг сонгон цөөн суралцагчийг зорилтот байдлаар ажиглаж, дараагийн өдрүүдэд бусдыг ээлжлэн ажиглаж болно. Ажиглалтыг суралцагчдыг хооронд нь харьцуулахад бус, дараагийн дэмжлэг, тохируулгыг төлөвлөхөд ашиглана.

Орчин, хэрэглэгдэхүүн ба аюулгүй байдал

Үйл ажиллагааг эхлэхийн өмнө тухайн өдөр ашиглах өрөө тасалгаа, хэрэглэгдэхүүн, сурагчийн дэвтрийн холбогдох хуудас, зурагт карт болон бусад материалыг урьдчилан бэлтгэнэ. Сургуулийн орчинд зорчих, тоглоомын талбайд тоглох, хайч болон бусад хэрэглэгдэхүүн хэрэглэх, хооллох зэрэг нөхцөлд аюулгүй ажиллагааг урьдчилан тооцож, шаардлагатай анхааруулга, зааварчилгааг тодорхой, ойлгомжтой өгнө.

Зөвлөмжид хэрэглэсэн тэмдэг, тэмдэглэгээ

Зөвлөмжид дараах тэмдэглэгээг ашигласан. Үүнд:

* тэмдэглэгээ нь “Би сурагч боллоо I” сурагчийн дэвтэрт тухайн үйл ажиллагаатай уялдсан дасгал байгааг илэрхийлнэ.

(1), (2), (3)... тэмдэглэгээ нь тухайн сэдвийн “Хэрэглэгдэхүүн” хэсэгт ижил дугаараар тэмдэглэсэн материалыг үйл ажиллагаанд ашиглахыг заана.

ХОЁР. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИШИГ ТӨЛӨВЛӨЛТ

Дараах жишиг төлөвлөлтөд сургуульд дасан зохицох эхний дөрвөн долоо хоногийн үйл ажиллагааг өдөр тутмын сэдэв, зорилго, хэрэглэгдэхүүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, чиглүүлэх асуулт, анхаарах зүйлтэй нь уялдуулан тусгав. Багш тухайн өдрийн зорилго, үндсэн чиглэлийг хадгалан сургуулийн орчин, суралцагчдын хэрэгцээнд нийцүүлэн тохируулж хэрэглэнэ.

I ДОЛОО ХОНОГ. МАНАЙ СУРГУУЛЬ

Эхний долоо хоногт суралцагч сургуулийн орчин, хүмүүс, өдөр тутмын дэгтэй танилцаж, сургууль дээр тайван, аюулгүй байж, өдөр тутмын үйл ажиллагаанд итгэлтэйгээр оролцох суурь нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ.

СЭДЭВ 1. МИНИЙ СУРГУУЛЬ

Өдрийн зорилго: Сурагч сургуулийн гадна, дотоод орчин, анги, ариун цэврийн өрөө, хооллох газар, эмчийн өрөө, биеийн тамирын заал зэрэг газрыг зураг, тэмдэглэгээ, бодит аяллаар таньж, багшийн дэмжлэгтэйгээр сургуулийн орчинтой танилцана.

Хэрэглэгдэхүүн: Өрөөний таних тэмдэг (1); гар угаах дараалал (2); ажил мэргэжлийн зурагт карт (3); сургуулийн гадна, дотор орчны бодит зураг (4);

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт (жишээ)
I, II	*Сургуультайгаа танилцаарай. - Багш өөрийгөө болон сургуулиа товч танилцуулна. - Сургуультайгаа танилцах аяллын зорилго, аялах үед баримтлах дэг, анхаарах зүйлийн талаар зурагт тулгуурлан ярилцана. Жишээлбэл, аялахдаа жагсаж явах, багшийн танилцуулсан анги, танхим, өрөөний зориулалт болон таних тэмдгүүдийг мэдэх, байршлыг тогтоох гэх мэт. Сургуулийн гадна болон дотор орчинтой танилцах аялал хийнэ. Аялах явцад: - Тэмдэг, тэмдэглэгээг тайлбарлан ярилцаж, өөрийн анги, ариун цэврийн өрөө болон бусад анги, танхимуудын байршил, зориулалт, олж очих тэмдэглэгээ, тэмдгийг мэддэг болно. (1) - Сургуулийн гадна, дотор орчинд “баруун гарын дүрэм”-ийг баримтлах, бусдыг түлхэхгүй, гүйхгүй, шат, хаалга болон бусад хэсэгт болгоомжтой явах дэгийг баримтална. - Боломжтой бол сургуулийн захирал, багш нарын өрөө болон бусад тохиромжтой газраар зочилж, багш, ажилтнуудтай танилцана. *Ариун цэврийн өрөөг олоорой. - Зураг дээрх анги, танхимыг нэрлэж, зориулалтын тухай ярилцана. - Зураг дээр ариун цэврийн өрөөг олж будаж/тэмдэглээд, хаана байсан, яаж очих талаар ярилцана.	- Энэ ямар газар вэ? - Зураг дээр хэн хэн байна вэ? - Тэд хаана байна вэ? - Зураг дээр юу байна вэ? Мэддэг зүйлүүдээ нэрлээрэй. - Тэд юу хийж байна вэ? - Хаалганы хажуу талын хананд ямар зураг байна вэ? - Сургуулиар аялах үедээ ямар дэг баримтлах вэ? - Энэ юуны таних тэмдэг вэ? - Энэ өрөө/анги бусдаасаа ямар ялгаатай вэ?

III	Үдийн хоол (Гар угаах). Гараа хэзээ угаадаг, яаж угаадаг талаар ярилцаж, дарааллын дагуу угаана. Гараа хэзээ угаадаг вэ? - Хоол идэхийн өмнө - Бие зассаны дараа - Гадаа тоглож, орсны дараа - Амьтан, бохир зүйлд хүрсний дараа - Ханиаж, найтаасны дараа - Гар бохирдсон үед заавал угаана. Үдийн хоолны өмнө гар угаах дараалал (2) 1. Гараа усаар норгоно. 2. Савангаар сайтар үрж угаана. 3. Усаар зайлна. 4. Алчуураар арчина.	- Гараа хэзээ угаадаг вэ? - Хоол идэхийн өмнө яагаад гараа угаах вэ? - Гараа яаж угаадаг вэ? - Хоолоо идэж дуусаад юу гэж хэлэх вэ?
IV, V	* Сургуульд ажилладаг хүмүүсийн талаар ярилцаарай. - Зурагт үзүүлсэн хүмүүсийн ажил мэргэжлийг хүүхдүүдээр нэрлүүлж, тухайн хүн юу хийдэг талаар ярилцана. - Багш, эмч, тогооч, үйлчлэгч, харуул зэрэг сургуулийн ажилтнуудын үүргийг хүүхдийн насны онцлогт тохируулан тайлбарлана. (3) - Хүүхдүүд дуртай мэргэжлийн талаар ярилцана. *Сурагчдын явах замыг олж, зураарай. - Хүүхдүүдийн өмссөн хувцсыг ажиглаад, хаана очих, ямар замаар явахыг олж будна. - Өмнөх цагуудад танилцсан сургуулийн орчны бодит зургийг ажиглан ярилцана. (4)	- Зураг дээр байгаа хүмүүсийн хувцас/гартаа барьсан зүйл/эргэн тойронд нь байгаа эд зүйлсийг ажиглаарай. - Юу хийдэг хүмүүс вэ? Чи яагаад тэгж бодсон бэ? - Хэн гэж дуудах вэ? - Хүү/Охин ямар хувцастай байна вэ? - Тэр хаана очих бол? Аль замаар явбал зөв газраа очих вэ? - Өнөөдөр шинээр юу мэдэж авсан бэ? - Чамд юу хамгийн их таалагдсан бэ? - Сургуульд ирсэн анхны өдөр ямар санагдсан бэ?

Анхаарах үйл:

- Энэ өдрийн үйл ажиллагаа нь сургалтын хөтөлбөрт туссан орчноо ажиглах, таних, ялгах, зураг болон тэмдэгт мэдээллийг ойлгох, өөрийн хэрэгцээг илэрхийлэх, өдөр тутмын зөв дадлыг хэрэгжүүлэх зэрэг суралцахуйн үр дүн, чадварыг дэмжих боломжтой. Гэхдээ эдгээрийг тухайн өдөр заавал бүрэн эзэмшүүлэх зорилго болгон тавихгүй, дасан зохицох үйл ажиллагааны явцад дэмжинэ.

- Сургуультай танилцах аяллын маршрут, хугацаа, сурагчдын тоо, багш болон дэмжлэг үзүүлэх ажилтны хуваарилалтыг сургуулийн түвшинд урьдчилан төлөвлөж, аюулгүй байдлыг хангана. Танилцах аялалд хөгжим, биеийн тамир болон мэргэжлийн багш нар ангийн багшид дэмжлэг үзүүлж, хамт явна.
- Сурагчид сургуулийн орчинд анх удаа зорчиж байж болох тул нэг дор олон өрөө, ажилтан, дүрэм танилцуулахгүй. Өдөр тутам хамгийн түрүүнд хэрэглэх анги, ариун цэврийн өрөө, хооллох газар, эмчийн өрөө, орох-гарах хэсгийг нэн тэргүүнд сонгоно.
- Сурагч тэмдэг, тэмдэглэгээг танихгүй байх, буруу хэлэх, ойлгохгүй үед зураг, тэмдэг, орчны баримжааг дахин ажиглуулж, өөрөө зөв шийдэл олоход нь дэмжлэг үзүүлнэ.
- Өдрийн турш сурагчийн сэтгэл хөдлөлийг ажиглаж, айдас, түгшүүр, ядрал илэрвэл богино хугацаанд амрах, багштайгаа хамт явах, танил орчинд түр саатах боломж олгоно.
- I ангийн математикийн 1.2б-д туссан орон зай, байршлыг тодорхойлох чадварыг сургуулийн өрөө тасалгаа, маршрут, тэмдэглэгээг бодитоор ажиглаж, олох үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлнэ. Мөн зураг, тэмдэглэгээг ажиглан ярилцах явцад монгол хэлний сонсох, ярих чадвар болон харилцах, суралцахууд суралцах чадамжийг дэмжих боломжтой.

- Анги танхимын хаалга, цонх, тавиур зэрэг сургуулийн орчинд байдаг танил зүйлсийнх нь талаар ярилцаж, дараагийн харилцаа эерэг, айдасгүй үргэлжлэх эхлэлийг тавина.

МИНИЙ СУРГУУЛЬ

Сургуультайгаа танилцаарай.



Сургуультайгаа танилцах аяллын зорилго, аялах үед баримтлах дэг, анхаарах зүйлийн талаар зурагт тулгуурлан ярилцана.

Сургуультайгаа танилцах аяллын дараа энэ дасгалыг ажиллана.



- Зураг дээрх анги, танхимыг нэрлэж, зориулалтын тухай ярилцана.



- Зураг дээр ариун цэврийн өрөөг олж будаж/тэмдэглээд, хаана байсан, яаж очих талаар ярилцана.

4


Сургуульд ажилладаг хүмүүсийн талаар ярилцаарай.



Сургуульд ажилладаг хүмүүсийн зургийг ажиглуулж, багшаас өөр эмч, тогооч, үйлчлэгч зэрэг хүмүүс ажилладаг болохыг ярилцана.



Хүүхдүүдийн явах замыг олж, зураарай.



- Хүүхдүүдийн өмссөн хувцсыг ажиглаад, хаана очих, ямар замаар явахыг олж, өнгийн харандаагаар дүүргэж будна.

(3)



СЭДЭВ 2. БИ ХЭНЭЭС ТУСЛАМЖ ХҮСЭХ ВЭ?

Өдрийн зорилго: Сургууль дээр ямар нөхцөлд, хэнд хандаж, хэрхэн тусламж хүсэж болохыг бодит жишээ, дүрд тоглох, зураг ажиглаж тайлбарлах аргаар мэднэ.

Хэрэглэгдэхүүн: Ажил мэргэжлийн зурагт карт (1); Зурагт карт(2)

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт (жишээ)
I	Сургуулийн ажилтнуудыг танья. - Багш сурагчдаа сургуулийн гадна угтан авч, анги руу дагуулан явахдаа үйлчлэгч, жижүүр, бусад багш нар гэх мэт замд таарсан ажилтнуудыг танилцуулж, хэн ямар ажил хийдэг тухай товч тайлбарлана. (Сургууль энэ үйл ажиллагааг зохион байгуулалттайгаар хийж болно) - Ажил мэргэжлийн зурагт карт (1) ашиглан “Би хэн бэ?” тоглоом тоглоно.	- Энэ хүн хэн бэ? - Тэр хаана ажилладаг вэ? - Юу хийдэг вэ? - Яаж таньсан байна бэ?
II	*Хэнээс ямар тусламж авах боломжтойг ярилцаарай. - Зургийг ажиглаад, ангиа олохгүй, ариун цэврийн өрөө орох хэрэгтэй байгаа, хөлөө гэмтээсэн, ус асгасан үед хэнд хандаж, хэрхэн тусламж хүсэж болохыг ярилцана. Боломжит хувилбаруудаас хамгийн оновчтой хувилбарыг сонгож харгалзуулна. - Дээрх жишээнээс гадна тохиолдож болох өөр нөхцөлүүдээр дүрд тоглох. (2)	- Энэ хүүхдэд юу хэрэгтэй байна вэ? - Хэрэв чамд ийм зүйл тохиолдвол хэнд хандах вэ? Яаж тусламж хүсэх вэ? - Хэн нэгэнд ийм зүйл тохиолдсон бол чи яаж туслах вэ?
III	Үдийн хоол (тусламж хүсэх). - Хооллох үеэр ангид/цайны газарт хэнээс, хэрхэн тусламж хүсэх, тусалсан хүнд хэрхэн талархсанаа илэрхийлэх талаар нийтлэг тохиолддог үйл явдалд тулгуурлан ярилцана. Зурагт карт ашиглаж болно. (2)	- Тусламж хэрэгтэй бол хэрхэн илэрхийлэх вэ? - Тусалсны хариуд юу гэж хэлэх вэ?
IV	*Хүүхэд бүрд хэн хэн тусалж чадахыг тохируулан холбоорой. - Зургийг ажиглаад ганцаардсан, үзгээ мартсан, хичээлээ ойлгохгүй байгаа, ангиа олохгүй байгаа хүүхдүүд хэнд хандаж болох талаар ярилцаж, тохирох зурагтай холбоно. (боломжит бүх хувилбарыг холбох) *Хүүхдүүд тусалж чадах хүндээ хандсан уу? - Зургийг ажиглаад тогооч ба хүүхдийн хооронд ямар яриа өрнөсөн байж болохыг таамаглан ярилцаарай. Охин/Хүү зөв хүндээ хандаж чадсан уу?	- Хүүхэд бүрд хэн тусалж чадах вэ? - Охин/Хүү тогоочоос ямар тусламж хүссэн бол? - Охин/Хүү зөв хүндээ хандаж чадсан уу?

Анхаарах зүйл

- Тусламж хүсэхийг бие даах чадваргүй гэж үнэлэхгүй; хэрэгцээгээ зөв илэрхийлэх чухал чадвар гэж бататгана.
- Тусламж хэрэгтэй нөхцөлийг таних, тохирох хүнээ сонгох, хэрэгцээгээ үг, дохио, хөдөлгөөнөөр илэрхийлэх, талархах үйлээр I ангийн монгол хэлний сонсох, ярих чадвар болон нийгмийн ухааны сургуулийн орчин дахь харилцаатай холбоотой үр дүнг үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлнэ. Үүний зэрэгцээ харилцах, шүүн тунгаах, нийгэм-сэтгэл хөдлөлийн чадамжийг дэмжинэ.

Зургийг ажиглаад, ангиа олохгүй, ариун цэврийн өрөө орох хэрэгтэй байгаа, хөлөө гэмтээсэн, ус асгасан үед хэнд хандаж, хэрхэн тусламж хүсэж болохыг ярилцана.

БИ ХЭНЭЭС ТУСЛАМЖ ХҮСЭХ ВЭ?

Хэнээс ямар тусламж авах боломжтойг ярилцаарай.



6

Боломжит хувилбаруудаас хамгийн оновчтой хувилбарыг сонгож харгалзуулна. Дээрх жишээнээс гадна тохиолдож болох өөр нөхцөлүүдээр дүрд тоглох.

Хүүхэд бүрд хэн хэн тусалж чадахыг холбоорой



Хүүхдүүд тусалж чадах хүндээ хандсан уу?



7

Дээд хэсэгт буй ганцаардсан хүү, үзгээ мартсан охин, ойлгохгүй байгаа хүү, ангиа олохгүй байгаа зэрэг хүүхдийн нөхцөлүүдийг ярилцаж, дараагийн хэсэгт байгаа туслах хүмүүстэй харгалзуулна. Хэрхэн харгалзуулснаа тайлбарлан ярилцана.

Хүүхдүүдийн хэн нь зөв хүнд хандсан болохыг ярилцаж, сургуулийн бодит боломжтой холбон тайлбарлана. Гол нь тусламж хүсэх энгийн хэллэг хэрэглэнэ.

(2)



СЭДЭВ 3. МАНАЙ АНГИ

Өдрийн зорилго: Анги доторх эд зүйл, хэрэглэгдэхүүний нэр, зориулалт, байрлалыг таньж, хэрэгтэй зүйлээ авч ашиглах, хэрэглэсний дараа тогтсон байранд нь буцаан тавих, ширээ орчмоо цэгцлэх үйлийг бодитоор туршина.

Хэрэглэгдэхүүн: Эд зүйлсийн зурагт картууд (1); ширээгээ цэгцлэх дэгийг харуулах зурагт карт (2);

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт (жишээ)
I	Сониуч галт тэрэг Хувилбар 1. Ангитай танилцах аялал. Багш галт тэрэгний толгой хэсэг болж сурагчдыг чиглүүлэн, анги доторх эд зүйлс, тэдгээрийн нэр, зориулалт, байршилтай танилцана. Шаардлагатай бол бусад багш нарын тусламжтайгаар хэд хэдэн групп болгон хувааж болно. *Хувилбар 2. Ангидаа байгаа эд юмсыг ажиглаад, ярилцаарай. Зургийг ажиглаад анги доторх эд зүйлс, тэдгээрийн нэр, зориулалт, байршлын талаар ярилцана. Зураг дээрх зүйлс ангид байна уу? Хэрэв байгаа бол хаана байна? гэсэн асуултаар харьцуулж ярилцан, хаана байгааг нь заалгана. (1)	- Энэ юу вэ? - Юунд хэрэглэдэг вэ? - Манай ангид хаана байна вэ? - Эд зүйлсийн байршлыг өөрчилж болох уу? Яагаад?
II	*Ангидаа байгаа эд юмсыг олж, будаарай. - Сурагч зургаас ангид байгаа зүйлсийг сонгон будна. - Будсан зүйлээ хаана байгааг зааж, хосоор ярилцана.	- Чи юуг будсан бэ? - Ангийн хаана байна вэ? - Юунд хэрэглэдэг вэ? - Яагаад будсан/будаагүй вэ?
III	Үдийн хоол (Хооллох үеийн дэг - Ширээгээ цэгцлэх) - Үдийн хоолонд орохын өмнө “Ширээгээ цэгцлэх дэгийг харуулах зурагт карт” (2)-ыг харуулж, ярилцана. 1. Ширээн дээрх хичээлийн хэрэгслээ хураана. 2. Гараа угаана. 3. Үдийн цайны алчуураа дэлгэнэ. 4. Хоолны хэрэгслээ цүнх/уутнаасаа гаргаж тавина. - Үдийн хоолоо иднэ.	- Хооллохын өмнө эхлээд гараа угаах уу? Эсвэл ширээгээ цэгцлэх үү? Яагаад? - Хоол идэхийн өмнө яагаад гараа угаах хэрэгтэй вэ? - Дэгийн дагуу ширээгээ цэгцлэхэд чамд тусламж хэрэгтэй юу? Ямар тусламж хэрэгтэй вэ? Хэнээс тусламж хүсэх вэ?

IV	Юуны байршил өөрчлөгдсөн бэ? - Багш хогийн сав, шохой/самбарын үзэг, үзгийн сав зэрэг хэд хэдэн зүйлийн байршлыг урьдчилан сольж, өөр газар тавьсан байна. - Ангид байгаа эд зүйлсийг ажиглаарай. Өөрчлөгдсөн зүйл байна уу? Юуны байршил өөрчлөгдсөн байна вэ? Байршил нь өөрчлөгдсөн зүйлсийг нэрлээрэй. Хаана байх ёстой вэ? гэх мэт асуултаар чиглүүлж, зөв байршилд нь байршуулахыг сурагчдаас хүснэ. Сурагчид хосоор ажиллана. *Тохирох байршилтай нь холбоорой. Ном, дэвтэр, алчуур, цэцэг зэрэг зүйлсийг ангийн тохирох байрлалтай нь холбоно. Холбохын өмнө эд зүйл бүрийг нэрлэж, хаана байрлахыг ярилцана.	- Юу өөрчлөгдсөн байна вэ? - Аль зүйлийн байршил солигдсон бэ? - Одоо хаана байна? - Хаана байх ёстой вэ? - Яагаад тогтсон байранд нь тавих хэрэгтэй вэ? - Бүх зүйл байрандаа орсон эсэхийг яаж шалгах вэ?
V	*Зураасны дагуу тодруулан зураарай. - Тасархай зураасыг ажиглаж, харандаагаа өөрт эвтэйхэн барин зураасны дагуу дагуулж зурна. - Багш шаардлагатай сурагчид эхлэх цэгийг заах, хөдөлгөөнийг загварчлан үзүүлэх, нэмэлт хугацаа өгөх зэргээр дэмжлэг үзүүлнэ. Цэгцэлье, хураая - Хэрэглэсэн хичээлийн хэрэгслээ үзгийн сав, цүнх болон тогтсон байранд нь хураана. - Ширээ, ойр орчмоо ажиглаж, байгаа хогийг зориулалтын саванд хийнэ. - Бүх зүйл байрандаа орсон эсэхийг хамтдаа шалгана.	- Зураасыг хаанаас эхлэх вэ? - Хэрэглэсэн зүйлээ хаана хураах вэ? - Ширээ, ойр орчмоо яаж цэгцлэх вэ? - Бүх зүйл байрандаа байгаа эсэхийг яаж мэдэх вэ?

Анхаарах зүйл:

- Зурагт байгаа эд зүйлсийг ангийн бодит орчинтой заавал холбон ажиглуулна.
- Нэр, зориулалт, байрлалыг багш шууд хэлэхээс илүү ажиглуулах, асуух, сонголт өгөх замаар өөрөөр нь олуулна.
- Авах → хэрэглэх → байранд нь буцаах → цэгцлэх үйлийг бодитоор хийлгэж, өдөр бүр давтана.
- Байршил өөрчлөхдөө зөвхөн хүүхэд аюулгүй авч, зөөж болох хөнгөн эд зүйл сонгоно.
- Даалгаврын тоо, хугацаа, дэмжлэгийг сурагчийн хэрэгцээ, оролцоонд тохируулна.
- Хосын ажилд хоёр сурагч хоёуланд нь ажиглах, нэрлэх, байрлуулах, тайлбарлах боломж олгоно.
- Үдийн хоолны үед зурагт картын ярилцлагыг богино байлгаж, үндсэн хугацааг бодит хооллох үйл ажиллагаанд зарцуулна.
- Зураас дагуулан зурахыг “цэвэр бичих” шалгалт болгохгүй; харандаа барих, чиглэл дагах, анхаарлаа төвлөрүүлэхэд дэмжлэг болгон ашиглана.
- Ангийн эд зүйлсийн нэр, зориулалт, байрлалыг ажиглах, байршлын өөрчлөлтийг таних, хэрэглэснээ байранд нь буцаах үйлээр математикийн 1.2б-д туссан байршил, чиглэлийн агуулгыг үйл ажиллагаанд шингээж хэрэгжүүлж болно. Хосоор ажиглах, нэрлэх, тайлбарлах явцад Монгол хэлний ярих чадвар болон хамтран ажиллах, суралцахууд суралцах чадамжийг дэмжинэ.

МАНАЙ АНГИ

Ангидаа байгаа эд юмсыг ажиглаад, ярилцаарай.



✓ Ангид байдаг эд юмсыг олж, будаарай.



Зурагт тулгуурлан
эсвэл сониуч галт
тэрэг аяллаас
сонгон ангид
байдаг эд
зүйлсийг нэрлэх,
тэдгээрийн
зориулалтыг
мэднэ.

Өгсөн
зургуудаас
өөрийн ангид
байгаа эд
зүйлсийг
сонгож будна.
Бүлсанаа


Тохирох байрлалтай нь холбоорой.



4-р цагийн үйл
ажиллагааны
дараа энэ
даалгаврыг
ажиллана.

Зураг дээрх
зүйлсийг нэрлэнэ.
Ном, дэвтэр бал,
самбарын алчуур,
цэцэг хаана байдаг
талаар ярилцаж,
тохирох зурагтай нь
холбоно.

Зураасны дагуу тодруулан зураарай.




Тасархай зураасны
дагуу хичээнгүй
тодруулан зурна.

(1)



(2)



**1. Хичээлийн
хэрэгслээ хураана**



2. Гарaa угаана



**3. Үдийн цайны
алчуураа дэлгэнэ**



**4. Хоолны хэрэгслээ
цунх, уутнаасаа
гаргаж тавина**

СЭДЭВ 4. БИ СУРГУУЛЬДАА ИРЛЭЭ

Өдрийн зорилго: Сурагч сургуульд ирэх үеийн мэдрэмжээ таньж, өөрийн боломжит хэлбэрээр илэрхийлнэ. Сургуульд ирэх зам, хэнтэй ирсэн, ямар мэдрэмж төрсөн, тайвшрах энгийн аргыг зураг, ярилцлага, хөдөлгөөнөөр туршина.

Хэрэглэгдэхүүн: Мэдрэмжийн карт (1); “Хооллох үеийн дэг” зурагт карт (2);

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт (жишээ)
I	*Чамд сурагч болох ямар санагдаж байна вэ? Тохирох зургийг сонгоорой. (Мэдрэмжээ таних, хуваалцах дасгал) - Багш өөрийн нүүрний хувирал, биеийн хөдөлгөөнөөр 2–3 өөр мэдрэмжийг үг хэлэлгүй үзүүлж, сурагчдаар ямар мэдрэмж байж болохыг таамаглуулна. Нүүрний хувирал, биеийн хөдөлгөөнөөс хүний мэдрэмжийг таамаглаж болох талаар товч ярилцана. - Сурагчид 4 ялгаатай нүүрний хувирлыг ажиглаж, зураг дээрх хүүхэд ямар байж болохыг ярилцана. Багш “Яагаад ингэж бодов?”, “Өөрөөр юу гэж хэлж болох вэ?” гэсэн асуултаар чиглүүлнэ. - Сургуульд анх ирсэн болон эхний өдрүүдэд өөрт төрсөн мэдрэмжээ эргэн санаж, өөрийн мэдрэмжтэй ойр зургийг сонгон будаж эсвэл тэмдэглэнэ. Нэгээс олон мэдрэмж төрсөн бол хэд хэдэн зураг сонгож болно. - Сурагч хүсвэл өөрийн сонгосон зургийг хостойгоо хуваалцана. Үгээр ярихад хүндрэлтэй бол зураг заах, нүүрний хувирал, дохио, хөдөлгөөнөөр илэрхийлж болно. - Мэдрэмжийн карт (1)-аас сонгон тухайн мэдрэмжийг нүүрний хувирал, гар болон биеийн хөдөлгөөнөөр үггүй илэрхийлэх тоглоом тоглоно. Бусад сурагч ямар мэдрэмж байж болохыг таамаглана. - Төгсгөлд “Эхний өдөр ямар байсан бэ? Өнөөдөр ямар байна?” гэж эргэн харж, мэдрэмж хүн бүрд өөр бөгөөд цаг хугацааны явцад өөрчлөгдөж болдог гэсэн санаагаар дүгнэнэ.	- Энэ хүүхэд ямар байгаа юм шиг харагдаж байна? Юунаас нь ингэж бодов? - Баяртай/санаа зовсон/айсан үед нүүр, бие маань яаж өөрчлөгдөж болох вэ? - Сургуульд анх ирэхэд чамд ямар байсан бэ? - Аль зураг чиний мэдрэмжтэй хамгийн ойр байна? Өөр нэг зураг бас тохирч байна уу? - Эхний өдөр болон өнөөдрийн мэдрэмж ижил байна уу, өөр байна уу? - Мэдрэмжээ үггүйгээр яаж илэрхийлж болох вэ? - Санаа зовсон эсвэл айсан үедээ хэнд хэлж, тусламж хүсэж болох вэ?
II	*Чи сургуульдаа хэрхэн, хэнтэй ирсэн бэ? - Сурагчид өнөөдөр сургуульдаа хэнтэй, хэрхэн ирснээ хостойгоо ярилцана. Жишээлбэл: аав, ээж, эмээ, өвөө, ах, эгчтэйгээ; явган, машинаар, сургуулийн автобусаар гэх мэт. - Зургийг ажиглаж, өөрийн сургуульдаа ирсэнтэй тохирох/хамгийн ойролцоо зургийг сонгон харгалзах дугуйг өөрийн дуртай өнгөөр будна. - Багш сурагчдын хариултыг сонсож, “Сургуульдаа аюулгүй ирэхэд бид юуг анхаарах вэ?” гэсэн асуултаар ярилцлагыг аюулгүй зорчих дадалтай холбоно.	- Чи өнөөдөр сургуульдаа хэнтэй ирсэн бэ? - Чи сургуульдаа яаж ирсэн бэ? - Замдаа юу (замын тэмдэг, амьтан, байшин, барилга, эд зүйлс) харсан бэ? - Сургуульдаа ирэхдээ хаагуур ордог вэ? - Зам хөндлөн гарахдаа юуг анхаарах вэ? - Машинаар/автобусаар ирвэл хаана буух нь аюулгүй вэ?

	- Сургуулийн бодит орчинд тохируулан орох-гарах хаалга, явган хүний гарц, автобусны зогсоол, авто зогсоол, замын тэмдэг, гэрлэн дохио, сургуулийн жижүүр зэргийг зураг, бодит жишээгээр сануулна. - Суралцагчид том хүнтэй, тодорхой маршрутаар зорчих, зөв гарц ашиглах, зам хөндлөн гарахдаа зогсож ажиглах, сургуульдаа ирсэн/явах гэж байгаагаа багшдаа заавал мэдэгдэх зэрэг 2–3 энгийн дүрмийг ярилцана. - Төгсгөлд нь сурагч бүр “Би сургуульдаа ирэхдээ ...-г анхаарна” гэсэн нэг санааг үгээр хэлэх, зураг заах эсвэл дохиогоор илэрхийлж болно.	- Сургуульдаа ирсэн гэдгээ хэнд мэдэгдэх вэ? - Тарахад хэнийг хүлээх вэ? - Хэрэв төөрвөл эсвэл эргэлзвэл хэнээс тусламж хүсэх вэ? - Аюулгүй ирэхэд хамгийн чухал нэг зүйл юу вэ?
III	Үдийн хоол (Хооллох үеийн дэг) - Сурагчийн дэвтрийн 11-р нүүрний гар угаах зургийг ажиглуулж, хооллохын өмнө болон ариун цэврийн өрөө хэрэглэсний дараа гараа угаах шаардлагатайг сэргээн сануулна. - “Хооллох үеийн дэг”-ийг харуулсан зурагт карт (2)-ыг ажиглуулж, зургуудыг зөв дараалалд оруулан ярилцана. 1. Ширээгээ цэгцэлж, хоолны хэрэгслээ гаргаж бэлдэнэ. 2. Гараа угаана. 3. Хоол тарааж байх үед байрандаа тайван сууж, ээлжээ хүлээнэ. 4. Хоолоо авахдаа багш, тогооч болон тусалсан хүнд талархсанаа илэрхийлнэ. 5. Хооллож дууссаны дараа хоолны хэрэгслээ зохих газарт байрлуулж, ширээ, ойр орчмоо цэгцэлнэ. - Үдийн хоолоо иднэ. - Дээрх дэгийг өдөр бүр давтан хэрэгжүүлж, хэвшил болгоно.	- Гараа хэзээ угаах вэ? - Хооллохын өмнө эхлээд юу хийх вэ? - Хоол тарааж байхад яагаад байрандаа тайван суух хэрэгтэй вэ? - Хоолоо авахдаа, дараа нь хэрхэн талархах вэ? - Хоолны дараа хоолны хэрэгслээ хаана тавих вэ? - Хооллож дууссаны дараа ширээ, ойр орчмоо яаж цэгцлэх вэ?
IV	*Сургууль чамд ямар санагдсан бэ? Зургуудыг ажиглаж, зураг бүрд хэн, хаана, юу хийж байгааг хосоор ярилцана. - Сурагч өөрийн сургууль дээр хийсэн зүйлтэй ижил эсвэл өөрт хамгийн ойр санагдсан зургийг сонгож, “Чамд юу хамгийн их таалагдсан бэ?”, “Яагаад?” гэсэн асуултаар өөрийн туршлага, сэтгэгдлээ найзтайгаа хуваалцана. - Хариулахыг хүссэн сурагч сонгосон зураг болон өөрийн сэтгэгдлээ ангийнхандаа хуваалцана. Багш “Хаана?”, “Хэнтэй?”, “Юу хийсэн?”, “Ямар санагдсан?” зэрэг богино, дөхүүлэх асуултаар санаагаа илүү тодорхой илэрхийлэхэд дэмжлэг үзүүлнэ. - Сурагчийн хариултыг заавал бүтэн өгүүлбэрээр шаардахгүй. Ярих, зураг заах, нүүрний хувирал, дохио, хөдөлгөөн зэрэг өөрт тохирох хэлбэрээр санаа, сэтгэгдлээ илэрхийлэх боломж олгоно. - Ярилцах явцад “Сургууль дээр надад таалагдсан зүйл...”, “Би ... хийх дуртай байсан”, “Надад ... тусалсан” гэх мэт энгийн эхлэл өгч, суралцагчийн яриаг дэмжинэ.	- Зураг дээр хэн, юу хийж байна вэ? - Аль зураг чиний хийсэн зүйлтэй адил байна вэ? - Сургууль дээр чамд юу хамгийн их таалагдсан бэ? - Яагаад тэр зүйл чамд таалагдсан бэ? - Сургуульд байхад чамд ямар санагддаг бэ? - Чи хэнтэй хамт юу хийсэн бэ? - Чамд хэн нэгэн тусалсан уу? Хэн тусалсан бэ? - Чамд тусалсан хүнд юу гэж хэлж болох вэ?

	- Сурагчдын анхаарал сарних, бие нь чилэх, сандарч түгших, тайван бус болох зэрэг шаардлагатай/тохиромжтой үед 11-р нүүрний доод хэсгийн гурвалжин зурлагыг дагуулан зуруулах, удаан амьсгаа авах–гаргах, гараа өвдөг дээрээ тавих, 1–3 хүртэл нам дуугаар тоолох зэрэг богино тайвшрах дасгал хийлгэнэ. Тайвшрах дасгалыг бусад үед ч хэрэгцээнд тохируулан ашиглаж болно. - Тайвшрах дасгал нь өөрийгөө тайвшруулж, дараагийн үйл ажиллагаанд оролцоход өөртөө туслах нэг арга болохыг суралцагчдад энгийнээр ойлгуулна.	- Сургууль дээр юуг дахин хийхийг хүсэж байна вэ?
--	---	---

Анхаарах зүйл:

- Сурагчийн мэдрэмжийг зөв/буруу, сайн/муу гэж үнэлэхгүй, илэрхийлэх хэлбэрийг нь хүндэтгэнэ.
- Сурагчийг заавал яриулахгүй, зураг заах, будах, дохио, хөдөлгөөнөөр илэрхийлэх боломж олгоно.
- Сургуульдаа ирэх, буцах аюулгүй байдлын зөвлөмжийг сургуулийн бодит орчин, маршрутад тохируулна.
- Хооллох үеийн дэг, зурагт картыг сургуулийн зохион байгуулалттай нийцүүлэн хувиргаж хэрэглэнэ.
- Үдийн хоолны 35 минутын үндсэн хугацааг бодит хооллох үйл ажиллагаанд зарцуулж, зурагт картын ярилцлагыг аль болох богино байлгана.
- Тайвшрах дасгалыг шаардлагатай, тохиромжтой үед богино хугацаагаар хийлгэнэ.
- Сурагчийн дэвтрийн зургийг бодит туршлагатай холбон ярилцах, сонгох, бататгах хэрэглэгдэхүүн болгон ашиглана.
- Өөрийн мэдрэмжийг таних, илэрхийлэх, сургуульд ирэх зам, аюулгүй зорчих байдлыг ярилцах үйлээр I ангийн нийгмийн ухаан, эрүүл мэндийн хөтөлбөрт туссан өөрийгөө таних, аюулгүй байдлаа хангахтай холбоотой чадвар, үр дүнг үйл ажиллагаанд шингээж хэрэгжүүлнэ. Мөн харилцах, нийгэм-сэтгэл хөдлөлийн хөгжил, суралцахууд суралцах чадамжийг дэмжинэ.

БИ СУРГУУЛЬДАА ИРЛЭЭ

Чамд сурагч болох ямар санагдаж байна вэ? Тохирох зургаас сонгоорой.



Чи сургуульдаа хэрхэн, яаж ирсэн бэ?



10

- Хүүхэд бүрийн зургийг ажиглаад, ямар мэдрэмжтэй байгаа тухай таамаглан ярилцана.

- Нүүрний хувирлаар ямар мэдрэмжтэй байгааг таамаглаж болдог тухай ярилцана.
- Хамгийн эхний өдрийн мэдрэмжээ зургаас сонголт хийж, тэмдэглэнэ.

Сургуульдаа хэрхэн ирж буй зургуудыг ажиглаж, сурагч өөрийн туршлагатай холбож сонгож, тайлбарлана.

Багш зургийг бодит үйлтэй холбож, тайлбарлаж ярилцахад асуулт даалгавраа чиглүүлнэ.

Сургууль чамд ямар санагдсан бэ?



Гараа угаагаарай.



Гар угаах үйлийг дадал болгоход чиглүүлж, бие даан гүйцэтгэх боломж олгоорой.



Амьсгалаа гаргах, тайвшрах заавар чиглүүлэг өгч зураасыг давхарлан зуруулна.

11

(1)



(2)

ХООЛЛОХ ҮЕИЙН ДЭГ

				
1. Ширээгээ цэгцэлж, хоолны хэрэгслээ гаргаж бэлдэнэ.	2. Гараа угаана.	3. Хоол тарааж байх үед байрандаа тайван сууж, ээлжээ хүлээнэ.	4. Хоолоо авахдаа талархсанаа илэрхийлнэ.	5. Хооллож дууссаны дараа хоолны хэрэгслээ зохих газарт байрлуулж, ширээ, ойр орчмоо цэгцэлнэ.

СЭДЭВ 5. СУРГУУЛИЙН НЭГ ӨДӨР

Өдрийн зорилго: Сургуулийн нэг өдрийн үйл ажиллагааны дарааллыг зурагт тулгуурлан тайлбарлана. (Мэндлэх, хичээллэх, гараа угаах, хооллох, дараалалд зогсох, аяга тавгаа хураах гэх мэт)

Хэрэглэгдэхүүн: Хооллох үеийн зурагт карт (1); “Аяга тавгаа хураах, ширээгээ цэвэрлэх дэг”-ийн зурагт карт (2); 43-р нүүрний хайчилбар зураг (3); хайч, цавуу (4);

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт (жишээ)
I	Юу хийснээ тоочин яриарай. - Сургуульдаа ирснээс эхлэн жагсаж ангидаа орох, суудалдаа суух хүртэл юу, юу хийснээ үйл явдлын дарааллын дагуу ярилцана. - Хэн хэнтэй мэндэлснээ тоочин хэлж, тоолно. * Мэндэлж сураарай. - Мэндлэх хэлбэрийг харуулсан 3 зургийг ажиглаж, ярилцана. - Жижүүртэй, багштай, ангийнхантайгаа хэрхэн мэндлэх талаар ярилцан, гаргасан санаагаа хосоор дүрд тоглож илэрхийлнэ. (“Сайн байна уу” гэж асуух, гар даллах, толгой дохих зэрэг 2–3 хувилбарыг турших) * Гар зүгшрүүлэх даалгавар. - Зурахдаа харандаагаа зөв барьж, тасархай зураасны дагуу хичээнгүй тодруулан зурна.	- Чи хэн хэнтэй мэндэлсэн бэ? - Нийт хэдэн хүнтэй мэндэлсэн бэ? - Яаж эелдгээр мэндлэх вэ? - Зураг дээр хэн хэн мэндэлж байна вэ? - Тэд яаж мэндэлж байна вэ? - Жижүүртэй яаж мэндэлж болох вэ? - Багштайгаа яаж мэндлэх вэ? - Найзтайгаа яаж мэндлэх вэ? - “Сайн байна уу?” гэж хэлэхээс өөрөөр яаж мэндэлж болох вэ? - Аль мэндлэх хэлбэр нь чамд хамгийн эвтэйхэн санагдаж байна вэ? - Чи найзтайгаа нэг мэндлэх хэлбэрийг туршиж үзэх үү?
II	Сонсоод, үйл явдлыг үргэлжлүүлэн ярилцаарай. - Багш үлгэр, эх зохиол, дууны хэсгээс ярьж/сонсоно. “Үйл явдал хэрхэн үргэлжлэх бол?” гэсэн асуултаар чиглүүлж, ярилцана. Жишээлбэл, “Манжин”, “Өнхрүүш”, “Арслан ба хулгана”, “Маамуу нааш ир”, “Гараа угаая” гэх мэт. *Үйл явдлыг зөв дарааллаар тайлбарлаарай. - Хооллох үеийн 4 зургийг ажиглан, үйл явдлын дараалал зөв эсэхийг ярилцана. - Багш зургуудыг самбарт байрлуулж, сурагчдаар зөв дарааллыг олуулна. (1) - Ярилцахдаа “Эхлээд, дараа нь, эцэст” гэсэн гурван холбоос үгийг ашиглаарай.	- Одоо юу болсон бэ? - Дараа нь юу болох бол? - Чи яагаад ингэж бодож байна вэ? - Хэрэв чи ... байсан бол дараа нь юу хийх байсан бэ? - Эдгээр зургаас аль нь хамгийн эхэнд байх вэ? - Дараа нь юу болох вэ? - Эцэст нь юу хийх вэ? - Энэ зураг зөв байрандаа байна уу? Яагаад? - Хэрэв энэ хоёр зургийн байрыг соливол юу өөрчлөгдөх вэ? - “Эхлээд..., дараа нь..., эцэст...” гэж ашиглаад бүх үйл явдлыг ярьж өгнө үү.

III	Үдийн хоол (Хооллох үеийн дэг – Хоолны хэрэгслээ хураах, ширээгээ цэвэрлэх). - Үдийн хоолонд орохын өмнө “Аяга тавгаа хураах, ширээгээ цэвэрлэх дэг”-ийн зурагт карт (2)-ыг харуулж, ярилцана. 1. Хоолны үлдэгдлээ зориулалтын саванд хийнэ. 2. Аяга, таваг, халбага, сэрээ, алчуураа уут/цүнхэнд хийнэ. 3. Ширээн дээр асгарсан болон ойр орчимд унасан хоолны үлдэгдлийг цэвэрлэнэ. 4. Гараа угаана. - Үдийн хоолоо иднэ. - Дэгийн дагуу ширээгээ цэвэрлэнэ.	Одоо дараа нь юу хийх вэ? Чи аль алхмыг өөрөө хийж чадсан бэ? Дууссаны дараа хэнд талархах вэ?
IV	* 43 дугаар нүүрний зургийг хайчилж, зөв дарааллаар наагаарай. - Хайч хэрэглэхдээ аюулгүй байдлыг сануулна. - Зургийг хайчилж 4 ширхэг карт болгон ашиглана. - Картаас сугалж, өмнөх болон дараагийн үйлийг явдлыг таамаглан ярилцана. (3) - Картыг дэвтэрт нааж, үйл явдлын дарааллыг сумаар тэмдэглэнэ.	- Зургийг ажиглаарай. Хүүхдүүд юу хийж байна вэ? - Энэ үйл явдал хэзээ болж байна гэж бодож байна? - Өмнө нь юу болсон байж болох вэ? - Дараа нь юу болох бол? - Сумаар аль зургаас аль зураг руу холбох вэ? - Хэрэв хоёр зургийн байрыг соливол дараалал зөв хэвээр байх уу? Яагаад?
V	*Хүүгийн явах замыг зураарай. - Хүү найзууд дээрээ очихын тулд яаж явах вэ? Зөв замыг олж будна. - Зам зурахдаа “баруун, зүүн, дээш, доош, тойроод” гэсэн чиглэл заасан үгсийг ашиглан ярилцах боломжийг олгоно. “Сургуулийн нэг өдөр” сэдвээр ярилцана. - Жишээлбэл: Өнөөдөр юу хийсэн бэ? Сургууль дээр ирээд юу хийсэн бэ? Юу сурч, мэдсэн бэ? Найздаа тусалсан уу? Хэн нэгнээс тусламж авсан уу? гэх мэт - (3)-г болон өмнөх өдрүүдийн хэрэглэгдэхүүнийг ашиглаж болно.	- Хүү хаашаа очих гэж байна вэ? - Хүү аль замаар явбал найзууд дээрээ очих вэ? - Эхлээд аль зүг рүү явах вэ? - Дараа нь баруун тийш үү, зүүн тийш үү? - Өнөөдөр сургууль дээр хамгийн эхлээд юу хийсэн бэ? - Дараа нь юу хийсэн бэ? - Өнөөдөр ямар шинэ зүйл мэдэж авсан бэ? - Хэн нэгэнд тусалсан уу? Хэн нэгнээс тусламж авсан уу? - Өнөөдрийн аль үйл ажиллагаа чамд хамгийн их таалагдсан бэ?

Анхаарах зүйл

- Үйл явдлын дарааллыг цээжлүүлэх бус, сурагчийн өдөр тутмын бодит үйлтэй холбон ойлгуулна.
- “Эхлээд, дараа нь, эцэст”, “өмнө, дараа” зэрэг үгийг зураг, бодит үйл дээр хэрэглүүлнэ.
- Сурагч заавал бүтэн өгүүлбэрээр яриулах албагүй; зураг заах, богино үг хэлэх, хөдөлгөөнөөр үзүүлэх боломж олгоно.
- Зурагт карт, дэвтрийг зөв хариу олох хэрэгсэл бус, ажиглах, ярилцах, дараалуулах хэрэглэгдэхүүн болгон ашиглана.

- Хооллох, гараа угаах, хураах дэгийг өдөр тутмын бодит үйл ажиллагаанд давтан хэвшүүлнэ.
- Хайч хэрэглэхдээ аюулгүй ажиллагааг сануулна.
- Багш зөв/бурууг шууд хэлэхээс өмнө “Яагаад?”, “Дараа нь юу болох вэ?” гэж өөрөөр нь тайлбарлуулна.
- Өдөр тутмын үйл явдлыг дараалуулах, “эхлээд, дараа нь, эцэст” гэж тайлбарлах, маршрут олох үйлээр I ангийн математикийн үйлдлийн дараалал, орон зай, чиглэлтэй холбоотой агуулга болон монгол хэлний сонсож ойлгох, дарааллаар ярих чадварыг үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлнэ. Мөн шүүн тунгаах, суралцахууд суралцах, харилцах чадамжийг дэмжинэ.

Багш мэндлэх хэлбэр, дарааллын үгсийг загварчилна. Сургууль дээр ирэхдээ мэндлэх үйл хийж буй эсэхийг тэмдэглэн гэр бүлийнхэнд нь чиглүүлэг өгч хамтран ажиллаж болно.


Сурагчийг зураг сонгож, “эхлээд–дараа нь–эцэст” гэж тайлбарлаж, өдөр тутмын дэгийн дарааллыг ойлгоход чиглүүлнэ.



12

Багш хайч зөв ашиглах, аюулгүй хэрэглэхийг сануулж, дарааллын дагуу байрлуулж, ярилцах, нааж эвлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.


Сурагчийг зам зурахдаа чиглэлийн үг хэрэглүүлнэ. Дараалал ба маршрутыг зурагт тулгуурлан сонгоно.



13

Будахдаа шугам давуулахгүй будах, харандаагаа зөв барихад нь багш дэмжлэг үзүүлнэ.

АЯГА ТАВГАА ХУРААХ, ШИРЭЭГЭЭ ЦЭВЭРЛЭХ ДЭГ



1. Хоолны үлдэгдлээ зориулалтын саванд хийнэ.



2. Аяга, таваг, халбага, сэрээ, алчуураа уут/цүнхэнд хийнэ.



3. Ширээн дээр асгарсан болон ойр орчимд унасан хоолны үлдэгдлийг цэвэрлэнэ.



4. Гараа угаана.

II ДОЛОО ХОНОГ. БИД НЭГ АНГИЙНХАН

Энэ долоо хоногийн үйл ажиллагаа нь суралцагчид бие биетэйгээ танилцах, бусдыг сонсох, ээлжээ хүлээх, туслах, талархах, бүлгийн ажилд оролцох замаар анги, хамт олныхоо нэг хэсэг гэдгээ мэдрэхэд чиглэнэ.

СЭДЭВ 6. НАЙЗУУДАЙГАА ТАНИЛЦЬЯ

Өдрийн зорилго: Ангийн найзуудтайгаа танилцах, тоглонгоо найзынхаа нэр, дуртай амьтныг мэдэх, хамтдаа хийх дуртай зүйлс, сайн үйлсийн талаар ярилцана.

Хэрэглэгдэхүүн: Зөөлөн бөмбөг (1), аяга, усны сав болон ам зайлах үйлдлийг харуулсан зурагт карт (2); “Хав хав жив жив” контентын зурагт карт (3);

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт (жишээ)
I	*Ангийнхантайгаа танилцаарай. - Сурагчид тойрог болж зогсоно. - Багш нэрээ хэлээд бөмбөгөө хажуугийн сурагчид дамжуулна. Бөмбөг авсан сурагч нэрээ хэлж, дараагийн найздаа дамжуулах байдлаар эхний тойрог дуусна. - Хоёр дахь тойрог эхлэхэд сурагч өөрийнхөө нэрийг биш найзынхаа нэрийг хэлээд бөмбөгөө тэр найздаа өгнө. (1) - Ангийн сурагчдын тооноос хамааран хэд хэдэн баг болгон хувааж болно. (Багийн тооноос шалтгаалан бөмбөг бэлтгэх, шаардлагатай бол биеийн тамирын багшийг оролцуулах)	- Нэрээ яаж тод, сонсогдохоор хэлэх вэ? - Найзынхаа нэрийг сайн сонсохын тулд юуг анхаарах вэ? - Дараагийн найздаа бөмбөгөө яаж дамжуулах вэ? - Найзынхаа нэрийг санаж байна уу? - Өөрийнхөө нэрийг хэлэх амархан байсан уу? Найзынхаа нэрийг хэлэх амархан байсан уу? - Найзынхаа нэрийг мартсан бол яаж асууж болох вэ? - Бөмбөгийг авахдаа, дамжуулахдаа юуг анхаарах вэ? - Тоглоомын дараа хэдэн найзынхаа нэрийг мэддэг болсон бэ?
II	*Найздаа өөрийгөө танилцуулаарай. - Зургийг ажиглаад, хоёр хүүхэд юу ярьж байгаа талаар хосоор ярилцана. - Найздаа өөрийгөө танилцуулж, дуртай амьтан, дуртай зүйлийнхээ тухай ярина. - Найзаасаа дуртай зүйлийнх нь талаар асууж, ярилцана. Энэ үед багш чиглүүлэх асуулт асууж дэмжлэг үзүүлнэ.	- Чиний нэр хэн бэ? - Чи ямар амьтанд дуртай вэ? - Чи ямар тоглоомд дуртай вэ? гэх мэт - Найзаасаа дуртай зүйлийг нь яаж асуух вэ? - Найз чинь юу гэж хариулсан бэ? - Та хоёрын дуртай зүйлээс ижил зүйл байна уу?
III	Үдийн хоол (Үдийн хоолны дэг – ам зайлах/цэвэрлэх) *Хоол идсэний дараа амаа зайлаарай. (2) - Яагаад ам зайлах хэрэгтэй талаар ярилцана. - Амаа зайлах дарааллыг зурагт тулгуурлан ярилцаж, боломжтой бол бодитоор хийлгэнэ.	- Хоол идсэний дараа аманд юу үлдэж болох вэ? - Амаа зайлахын өмнө юу бэлдэх вэ? - Амаа зайлахдаа ямар дарааллаар хийх вэ? - Амаа зайлсан усаа хаана асгах вэ? - Яагаад амаа зайлах хэрэгтэй вэ? - Угаалтуур байхгүй бол яах вэ?

	- (Сургууль, ангийн орчинд тохируулан ам цэвэрлэх аргыг туршаарай. Жишээлбэл, балга усаар амаа зайлж салфетканд авах, шүдээ нойтон салфеткаар арчих гэх мэт)	
IV	*Сонсоод, үйл явдлын дарааллыг тогтоогоорой. https://medle.mn/additionallesson/2/261/100004547145612/play - medle.mn / нэмэлт контент / “Хав хав, жив жив” аудио контентыг сонсох (3) - Контентын цуврал 4 зургийг ажиглаад, үйл явдлыг зөв дараалалд оруулж ярина.	- Эхлээд ямар амьтантай таарсан бэ? Яаж тусалсан бэ? - Дараа нь ямар амьтантай таарсан бэ? Яаж тусалсан бэ? - Зураг бүрд хэн, юу хийж байна вэ? - Аль зураг эхний үйл явдлыг харуулж байна вэ? - Энэ зургийн дараа аль зураг орох вэ? Яагаад? - Хамгийн сүүлд юу болсон бэ? - Зургийн дарааллыг өөрчилбөл яах вэ?
V	*Найзтайгаа хамт хийх дуртай зүйлээ ярилцаарай. - Зургийг ажиглаад найзтайгаа хамт юу хийдэг, юу хийж болох талаар ярилцана. *Сайн үйл хийж буй хүүхдүүдийг сонгоорой. - Өгсөн 4 зургийг ажиглаад, “Яагаад сайн үйл гэж бодсон бэ? Яагаад муу үйл гэж бодсон бэ?” гэх мэт асуултаар чиглүүлэн ярилцана.	- Зураг дээр хүүхдүүд хамтдаа юу хийж байна вэ? - Чи найзтайгаа хамт юу хийх дуртай вэ? - Хамт хийхэд юу нь хөгжилтэй байдаг вэ? - Санал зөрвөл яаж шийдэх вэ? - Чи найздаа яаж туслах вэ? - Зураг дээр хүүхдүүд юу хийж байна вэ? - Аль үйлдэл тус болж байна вэ? Яагаад? - Аль үйлдэл бусдыг гомдоож эсвэл төвөг учруулж байна вэ? Яагаад? - Чи ийм үед найздаа яаж туслах вэ? - Хэрвээ чи түүний оронд байсан бол яах вэ?

Анхаарах зүйл

- Сурагч бүрийг нэрээ хэл, найзынхаа нэрийг сана гэж шахахгүй.
- Хосоор ярилцах үед сурагч бүрд асуух, сонсох, хариулах, ээлжээ хүлээх боломж олгоно.
- Дуртай амьтан, хамт хийх зүйлсийн ялгааг зөв/буруу гэж үнэлэхгүй, харин ижил, ялгаатай байдлыг хүндэтгэхэд чиглүүлнэ.
- “Сайн/муу хүүхэд” гэж ялгахгүй, харин тухайн үйлдэл нь бусдад хэрхэн нөлөөлж байгааг ярилцана.
- Контент, зурагт картыг ажиглах, дараалуулах, тайлбарлах, өөрийн туршлагатай холбон хэрэглэгдэхүүн болгон ашиглана.
- Ярих чадвар ялгаатай сурагчдад зураг харж ярих, богино үг, дохио, хөдөлгөөнөөр илэрхийлэх боломж олгоно.
- I ангийн монгол хэлний сонсох, асуух, хариулах, өөрийгөө танилцуулах, үйл явдлыг дарааллаар ярих; нийгмийн ухааны бусадтай харилцах, хамтран оролцох, туслах; эрүүл мэндийн амны хөндийн эрүүл ахуйн зөв дадалтай холбоотой суралцахуйн үр дүн, чадварыг танилцах тоглоом, хосын ярилцлага, зураг ажиглах, контент үзэж үйл явдлыг дараалуулах, хамтын үйл ажиллагаагаар дэмжинэ.

Бөмбөг дамжуулж тоглоонгоо нэрээ хэлж, найзынхаа нэрийг тогтооно. Багш нэрээ хэлж, бөмбөг дамжуулснаар тоглоом эхэлнэ.

НАИЗУУДТАЙГАА ТАНИЛЦААРАЙ.

Ангийнхантайгаа танилцаарай.



Найздаа өөрийгөө танилцуулаарай.



Ширээний найздаа өөрийнхөө дуртай зүйлс, амьтдыг хэлнэ. Мөн найзынхаа дуртай зүйлсийг мэдэж авна.

Үдийн цайнд орохын өмнө ам зайлах дарааллыг мэдэж авна. Хоолны цаг дээр яагаад амаа зайлах хэрэгтэй талаар ярилцаж, хэрэгжүүлнэ.

Үдийн хоолоо идсэний дараа амаа зайлах.



Сонсоод, үйл явдлын дарааллыг тогтоогоорой.



Контент сонсоод, зургийг үйл явдлын зөв дараалалд оруулж, бусдадаа ярьж өгнө.

Найзтайгаа хамт хийх дуртай зүйлсийнх нь талаар зурагт тулгуурлан ярилцана.

Найзтайгаа хамт хийх дуртай зүйлээ ярилцаарай.



✓ Сайн үйл хийж буй хүүхдүүдийг сонгоорой.



Зургийг ажиглаад, хүүхдүүдийн гаргаж байгаа сайн, муу үйлдлийг ярилцаж, сайн үйл гэж бодсон зургийг сонгоно.

СЭДЭВ 7. СОНСЪЁ, ЭЭЛЖЭЭ ХҮЛЭЭ

Өдрийн зорилго: Бусдын хэлсэн үг, зааврыг анхааралтай сонсож, түүнд тохирох үйлдэл хийн, ээлж дараалалтай оролцож сурна.

Хэрэглэгдэхүүн: Багшийн зааврыг илэрхийлсэн зурагт карт (1); “Ярьж байна”, “Сонсож байна”; “Ээлжээ хүлээж байна” гэсэн зурагт карт (2); үдийн хоолны үеэр мөрдөх дэг (3); ээлж дарааллыг харуулсан зурагт карт (4)

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт (жишээ)
I	Сонсож суръя. - “Босоорой”, “Суугаарай”, “Алга ташаарай”, “Гараа өргөөрэй”, “Чимээгүй сууя” гэх мэт зааврыг зурагт картаар сурагчдад харуулж, хийлгэнэ. (1) - Энэ үйлдлийг нэг нь үгээр хэлж, нөгөө нь үйлдлийг гүйцэтгэх тоглоом тоглоно. Тоглох явцад заавраа анхааралтай сонсож, хийж байгааг эсэхийг багш ажиглаж тохирох чиглүүлэг өгч, дэмжлэг үзүүлнэ. - Нэг нь ярьж байхад нөгөө нь анхаарч сонсох хэрэгтэй талаар багш сурагчдад тайлбарлаж өгнө. *Бусдыг сонсож буй хүүхдийг сонгоорой. - Зургийг ажиглаад, асуултын дагуу ярилцана. Бусдыг сонсож, зэрэг ярихгүй, хүлээцтэй сууж байгаа хүүхдийг сонгоно.	- Багш ямар заавар өгсөн бэ? - Зааврыг сонсоод чи юу хийсэн бэ? - Найз чинь юу гэж хэлсэн бэ? - Найзынхаа үгийг сайн сонсохын тулд яах вэ? - Нэг хүн ярьж байхад бусад нь яах вэ? - Зааврыг анхааралтай сонсох нь яагаад хэрэгтэй вэ? - Аль хүүхэд найзыгаа сонсож байна вэ? Яаж мэдсэн бэ? - Хоёулаа зэрэг яривал юу болох вэ?
II	*Дуртай тоглоомоо танилцуулаарай. - Сурагчид тойргоор зогсож/сууж, бөмбөг дамжуулж тоглоно. (Хэнд ч дамжуулж болно.) - Сурагч бөмбөгийг дараагийн хүүхэд рүү дамжуулахдаа ямар тоглоомд дуртайг нь асууна. - Бөмбөгтэй сурагч тоглох дуртай тоглоомоо нэрлээд, танилцуулна. - Танилцуулж дуусаад дараагийн сурагч руу бөмбөгөө дамжуулна. - Нэг нь асууж, нөгөө нь хариулж байх үед бусад сурагч анхааралтай сонсож, идэвхтэй оролцож байгаа эсэхийг багш ажиглан, жигд оролцоог дэмжинэ.	- Чиний дуртай тоглоом юу вэ? - Ганцаараа тоглодог уу, найзтайгаа тоглодог уу? - Найзыгаа ярьж байх үед чи яах ёстой вэ? - Зөвхөн бөмбөгтэй сурагч ярьж байгаа нь чамд ямар санагдсан бэ? Яагаад?

III	Үдийн хоол (Үдийн хоолны дэг - ээлжээ хүлээх) Үдийн хоолны үеэр яагаад жагсаж явах, яагаад ээлжээ хүлээн хоолоо авах талаар ярилцана. - Ээлж, дараалалтай хоолоо аваагүйн улмаас үүсэж болох эрсдэлүүдийг харуулсан зурагт карт үзүүлж, ярилцана. (4) *Зөв үйлчлүүлж байгаа сурагчдыг сонгоорой. - Өгсөн 2 зургийг харьцуулан ажиглаж, хоолны газраар зөв үйлчлүүлж байгаа сурагчдын зургийг сонгоно.	- Зураг дээр хүүхдүүд юу хийж байна вэ? - Аль зурагт хүүхдүүд ээлжээ хүлээж байна вэ? - Хоолоо авахдаа яаж дараалж зогсох вэ? - Яагаад бусдын урдуур орж болохгүй вэ? - Ээлж дайрвал юу тохиолдож болох вэ? - Яарч, түлхэлцвэл ямар эрсдэл гарч болох вэ? - Өөрийн ээлж ирэх хүртэл яаж хүлээх вэ? - Хоолоо авсныхаа дараа дараагийн хүнд яаж зай гаргах вэ?
IV	*Яагаад ээлжээ хүлээх хэрэгтэйг ярилцаарай. - Сурагчдыг дөрвөн багт хуваана. - Баг бүр гулсуураар гулгаж, гараа угааж, хувцсаа өлгөж/авч, гараа өргөн хариулж байгаа сурагчдын зургаас сугалж, асуултын дагуу ярилцана. - Баг дотроо ярилцсаны дараа нөгөө 3 багтаа танилцуулна. Ингэхдээ баг бүрээс нэг, нэг гишүүн зургаа бариад багуудаар тойрч танилцуулна. (4)	- Энэ зурагт хүүхдүүд юу хийж байна вэ? - Ээлжээ хүлээхгүй бол юу тохиолдож болох вэ? - Бусдын урдуур орвол найзад нь ямар санагдах бол? - Хувцсаа өлгөх, авахдаа яаж бусдад саад болохгүй байх вэ? - Энэ зураг бидэнд ямар дэгийг сануулж байна вэ?

Анхаарах зүйл:

- Ээлжээ хүлээх дадлыг зөвхөн тайлбарлах бус тоглоом тоглох, хооллох, гараа угаах, хариулах зэрэг бодит нөхцөлд давтан дадлагажуулна.
- Хүүхэд бүрд ярих, сонсох, сонголт хийх, ээлжээр оролцох боломж олгож, хос болон багийн ажилд цөөн сурагч давамгайлахаас сэргийлнэ.
- I ангийн монгол хэлний сонсох, ярих; нийгмийн ухааны бусадтай харилцах, хамтран оролцох; суралцахуйд суралцах болон нийгэм-сэтгэл хөдлөлийн чадамжийг заавар дагах, дуртай тоглоомоо танилцуулах, бусдын яриаг сонсох, ээлжээ хүлээх, багийн ярилцлагад оролцох үйлээр дэмжинэ.

Зургийг ажиглаад, багшийн чиглүүлэх асуултын дагуу ярилцана. Бусдыг сонсож, зэрэг ярихгүй, хүлээцтэй сууж байгаа хүүхдийг сонгоно.

СОНСЪЁ, ЭЭЛЖЭЭ ХҮЛЭЭ



Бусдыг сонсож буй хүүхдийг сонгоорой.





Дуртай тоглоомоо танилцуулаарай.




Сурагчид бөмбөг дамжуулж тоглоомоо дуртай тоглоомоо нэрлэж, танилцуулна.



Зөв үйлчлүүлж байгаа сурагчдыг сонгоорой.



Яагаад ээлжээ хүлээх хэрэгтэйг ярилцаарай.



Өгсөн зургийн орчин, нөхцөл байдлыг харьцуулан ажиглаж, хоолны газраар зөв үйлчлүүлж байгаа сурагчдын зургийг сонгоно.

Баг болон хуваагдана. 4 зургаас нэгийг санамсаргүйгээр сонгож, багаараа ярилцана. Ярилцсанаа бусад багтаа танилцуулна.

(1)




(2)



Ярьж байна



Сонсож байна



**Ээлжээ
хүлээж байна**

(3)



(4)



СЭДЭВ 8. БИДНИЙ ДҮРЭМ

Өдрийн зорилго: Суралцагч ангийн өдөр тутмын үйл ажиллагаанд дүрэм хэрэгтэйг ойлгож, бусдад саад болохгүй, аюулгүй, тайван, хамтран суралцахад чиглэсэн ангийн дүрмийг хамтран зохионо.

Хэрэглэгдэхүүн: Эерэг болон сөрөг үйлдлийг харуулсан зурагт карт (1);

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт (жишээ)
I	*Аюулгүй зорчиж буй зургийг сонгоорой. - Зургийг ажиглаад, хүүхэд хаана, юу хийж байгаа талаар хосоор ярилцана. - Хүүгийн хийж буй үйлдлийг зөв гэж бодож багаа бол ✓ тэмдгээр, буруу гэж бодож байгаа бол × тэмдгээр тэмдэглэж, яагаад тэгж бодсоноо найздаа тайлбарлана. Сурагчдын ярианаас машинд мөргүүлэх аюултай гэсэн дүгнэлт гарна. - Багш “Энэ эрсдэлээс хэрхэн сэргийлэх вэ?” асуултаар чиглүүлэн ярилцаж, замын хөдөлгөөний дүрмийг мөрдөх ёстой гэсэн дүгнэлтэд хүргэнэ. - Дүрэм баримталснаар ямар аюул, эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалж болох талаар найзтайгаа ярилцана. - Сурагчдын харилцан яриаг нэгтгэн дүгнэж, хичээлийн цагийг дуусгана.	- Зураг дээр хүүхдүүд хаана, юу хийж байна вэ? - Аль хүүхэд аюулгүй зорчиж байна вэ? Яаж мэдсэн бэ? - Аль үйлдэл аюултай байна вэ? Яагаад? - Дүрмээ баримтлахгүй бол өөрт болон бусдад юу тохиолдож болох вэ? - Зам гарахын өмнө эхлээд яах вэ? - Яагаад заавал явган хүний гарцаар гарах хэрэгтэй вэ? - Яагаад замын хөдөлгөөнд дүрэм хэрэгтэй вэ?
II	*Ажиглаад, хүүхдүүдийн үйлдлийг тайлбарлаарай. - Зургийг ажиглаад, хүүхдүүд хаана, юу хийж байгааг багаар/хосоор ярилцаж, зураг тус бүрээр тухайн үйлдэл нь бусдад ямар таагүй мэдрэмж үүсгэж болохыг ярилцана. Хүүхдийг “муу” гэж нэрлэхгүй, зөвхөн үйлдлийг ярилцана. - Багш эерэг болон сөрөг үйлдлийг харуулсан зурагт карт үзүүлнэ. (1) Сурагчид зөв гэж бодвол 2 удаа алга ташна, бусдад аюултай гэж бодвол хоёр гараа зөрүүлнэ. Жишээлбэл, “Найзаасаа асуугаад харандааг нь авах”, “Коридорт түлхэлцэх”, “Найзыгаа сонсох”, “Шоолох” гэх мэт. - Хос бүр нэг зураг сонгож, эхлээд зурагт байгаа нөхцөлийг товч тайлбарлана. Дараа нь тухайн үйлдлийг эерэг хувилбараар дүрд тоглоно. Жишээлбэл, гүйхгүйгээр тайван алхах; шоолохгүй эелдгээр харилцах; хашхирахгүйгээр гараа өргөж ярих; эд зүйл авахдаа зөвшөөрөл хүсэх. - Багш сурагчийн дэвтэр дэх зураг тус бүрийг дахин харуулж, сурагчдаар дүгнэн хэлүүлнэ.	- Зураг дээр хүүхдүүд юу хийж байна вэ? - Аль үйлдэл бусдад саад болж байна вэ? - Энэ үйлдэл найзад нь ямар санагдах бол? - Түлхэх, шоолох, чанга дуугарах нь ямар зөв үү? Буруу юу? Яагаад? - Бусдын эд зүйлд хүрэхийн өмнө яах ёстой вэ? - Найзтайгаа санал зөрсөн үед яаж эергээр шийдэх вэ? - Бид бусдад саад болохгүй байхын тулд юуг анхаарах вэ? - Бүгд өөрийнхөө хүссэнээр байвал ангид юу болох бол?
III	Үдийн хоол (Үдийн хоолны хэрэгслээ арчлах). - Үдийн хоолны өмнө: Аяга, халбага, сэрээ, усны сав болон уут нь цэвэр байгаа эсэхийг сурагчдаар ажиглуулна.	- Хоолны үлдэгдэл үлдвэл яах вэ? - Бохир эсвэл нойтон хэрэгслээ шууд цүнхэнд хийвэл юу болох вэ? - Аяганы уут бохирдвол яах вэ?

	- Хооллосны дараа үлдэгдлийг зориулалтын саванд хийх, хэрэгслээ цэвэрлэж/арчлаад уутанд нь хийх дарааллыг багш товч үлгэрлэн үзүүлнэ. - Хоолны хэрэгслээ бохир, нойтон чигээр нь цүнхэнд хийхэд ном, дэвтэр болон бусад зүйл бохирдож болохыг бодит жишээгээр ярилцана. - Сурагч бүр өөрийн аяга, халбага, уутыг цэвэр, хуурай эсэхийг шалгаж, цүнхний тодорхой хэсэгт хийнэ. - Үдийн хоолоо иднэ. - Хоолны дараа: Хоолны хэрэгслээ “цэвэрлэх”, “уутанд хийх”, “цүнхэнд хийх” гэсэн дарааллаар бүх суралцагч өөрийгөө шалгана.	- Хоолны хэрэгслээ цүнхний хаана хийх нь зөв вэ? - Ном, дэвтрээ бохирдуулахгүй байхын тулд юуг анхаарах вэ?
IV	*Зургийг ажиглаад, ангийн дүрмээ гаргаарай. - Зургийг ажиглаад, сурагчдын хийж байгаа үйлдлийг хосоор ярилцана. - Зурагт байгаа үйлдлүүдээс манай ангид хэрэгтэй, хамтдаа мөрдөж болох дүрмийг хамтран сонгоно. - “Энэ дүрэм бидэнд яагаад хэрэгтэй вэ?” гэсэн асуултаар чиглүүлж, нийтээр мөрдөх дүрмийг зохионо. - Зохиосон дүрмээ дүрд тоглон, туршина.	- Сурагчид юу хийж байна вэ? - Аль нь манай ангид хэрэгтэй дүрэм бэ? - Бусдад саад болохгүйн тулд ямар дүрэм хэрэгтэй вэ? Дүрмээ зохиоё. - Энэ дүрмийг дагаж чадна гэж бодож байна уу? Яагаад? - Дүрмээ мөрдөхгүй бол яах вэ? - Бидний сонгосон дүрмээс аль нь хамгийн чухал вэ? Яагаад? - Дүрмээ өдөр бүр яаж санаж, мөрдөх вэ?
V	*Зургаас зөв үйлдлийг сонгоорой. - Зургийг ажиглаж, зураг бүр дээр хүүхдүүд юу хийж байгааг хосоор ярилцана. - Зурагт байгаа үйлдлүүдээс зөв үйлдэл болон бусдад саад болох үйлдлийг ялгана. - Сурагчид зөв гэж үзсэн зургийг сонгож, будаж эсвэл тэмдэглэнэ. Ангийн дүрэмтэйгээ холбон тайлбарлана. - “Яагаад энэ нь зөв үйлдэл вэ?”, “Яагаад энэ нь бусдад саад болж байна вэ?” гэсэн асуултаар ярилцана. - Алжаал тайлах дасгал хийнэ.	- Зураг дээр хүүхдүүд юу хийж байна вэ? - Аль зурагт зөв үйлдэл харагдаж байна вэ? - Яагаад энэ үйлдлийг зөв гэж бодож байна вэ? - Аль үйлдэл бусдад саад болж байна вэ? - Энэ үйлдэл найзад нь ямар санагдах вэ? - Бусдад төвөг болохгүй байхын тулд яах хэрэгтэй вэ? - Чи энэ зургаас алийг нь дуурайж хийхийг хүсэж байна вэ?

Анхаарах зүйл:

- Үйл ажиллагааг зохион байгуулах явцад сурагчдын анхаарал сарних, уйдах хандлага ажиглагдвал “Зааврыг дагая” алжаал тайлах хөдөлгөөнт дасгалыг хийлгэж болно.
 - Багш “Алхаарай”, “Зогсоорой”, “Гараа өргөөрэй”, “Чимээгүй сууя”, “Найз руугаа инээмсэглээрэй” гэх мэт заавар хэлнэ.
 - Суралцагчид зааврыг сонсож, үйлдлээр үзүүлнэ.
- “Ангийн дүрэм бол бидний дүрэм” түүнийг дагаж мөрдсөнөөр эрсдэл үүсэхгүй, бусдад саад болохгүй гэсэн санааг ойлгуулахыг хичээгээрэй.
- Дүрмийг тогтмол сануулах, байнга давтсанаар дадал хэвшил болно.

Зургийг ажиглаад, хүүхэд хаана, юу хийж байгаа талаар хосоор ярилцана. Хүүгийн хийж буй үйлдлийг зөв гэж бодож багаа бол ✓ тэмдгээр, буруу гэж бодож байгаа бол × тэмдгээр тэмдэглэж, яагаад тэгж бодсоноо найздаа тайлбарлана.

БИДНИЙ ДҮРЭМ

Аюулгүй зорчиж буй зургийг сонгоорой.



Зургийг ажиглаад, хүүхдүүд хаана, юу хийж байгааг багаар/хосоор ярилцаж, зураг тус бүрээр тухайн үйлдэл нь бусдад ямар таагүй мэдрэмж үүсгэж болохыг ярилцана. Хүүхдийг “муу” гэж нэрлэхгүй, зөвхөн үйлдлийг ярилцана.

Ажиглаад, хүүхдүүдийн үйлдлийг тайлбарлаарай.



19

Зургийг ажиглаад, ангийн дүрмээ гаргаарай.



✓ Зургаас зөв үйлдлийг сонгоорой.



20

Зургийг ажиглаад, сурагчдын хийж байгаа үйлдлийг хосоор ярилцана. Зурагт байгаа үйлдлүүдээс манай ангид хэрэгтэй, хамтдаа мөрдөж болох дүрмийг хамтран сонгоно. “Энэ дүрэм бидэнд яагаад хэрэгтэй вэ?” гэсэн асуултаар чиглүүлж, нийтээр мөрдөх дүрмийг зохионо. Зохиосон дүрмээ дүрд тоглон, туршина.

Зургийг ажиглаж, зураг бүр дээр хүүхдүүд юу хийж байгааг хосоор ярилцана. Зурагт байгаа үйлдлүүдээс зөв үйлдэл болон бусдад саад болох үйлдлийг ялгана. Сурагчид зөв гэж үзсэн зургийг сонгоно. Ангийн дүрэмтэйгээ холбон тайлбарлана.

(1)





Сурагчид ангийн дүрмээ гаргахдаа олон зөв үйлдлийн тухай хэлсэн байх, тэр бүрийг харуулах боломжгүй учраас багш иймэрхүү карт хийгээд хэвлээд сурагчдад тарааж, хэлүүлэх, сонгуулах, яриулах хэлбэрээр ашиглаж болох санаа юм.

СЭДЭВ 9. ТУСАЛЪЯ, ТАЛАРХЪЯ

Өдрийн зорилго: Бусдаас эелдгээр тусламж хүсэх, чадах зүйлээрээ туслах, талархсан сэтгэлээ илэрхийлэх үг хэллэгийг бодит үйл дээр тулгуурлан хэрэглэх, бусдад туслах энгийн дадалд суралцана.

Хэрэглэгдэхүүн: Нэг нэгэндээ тусалж болох тохиолдлуудыг харуулсан зурагт карт (1); дууны утгыг илэрхийлсэн зурагт карт (2); хүнсний ногоо болон зурагт карт (3)

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт (жишээ)
I	*Тусламж хэрэгтэй байгаа хүүхдийг олоорой. - Зургийг ажиглаад, сурагчид юу хийж байгааг ярилцана. - Хэрвээ чи хүүгийн оронд байсан бол яах байсан бэ? Асуултын дагуу бусдад хэрхэн тусалж болохыг ярилцана. “Бусдад тусалъя, талархъя” дүрд тоглоё. - Нэг нэгэндээ тусалж болох тохиолдлуудыг харуулсан зурагт картаас сонгож, хосоор дүрийн тоглолт хийнэ. (1) - Энэ үйл ажиллагаагаар дамжуулж чадах зүйлээрээ бусдад тусалдаг, чадахгүй байгаа үедээ бусдаас эелдгээр тусламж хүсдэг, өөрт тусалсан нэгэнд “Баярлалаа” гэж хэлдэг болохыг ойлгоно.	Зураг 1. - Охин хүү хоёрын хэнд нь тусламж хэрэгтэй болсон бэ? - Хүү охинд юу өгч байна вэ? - Хүү юу гэж хэлсэн бол? - Охин юу гэж хэлсэн бол? - Найздаа туслах нь зөв үү? - Хэрвээ чи хүүгийн оронд байсан бол яах байсан бэ? - Тусалсны хариуд найздаа талархсан сэтгэгдлээ ямар үгээр илэрхийлэх бол?
II	*Хамтдаа дуулаарай. - Хөгжмийн багштай хамтран Ө.Баасанжавын үг, С.Мааяагийн ая “Сайн уу, муу юу аль нь вэ хө? дуунаас сайн муу үйлийг харуулсан бадгийг сонгон авч заана. (Бүтэн заахгүй) - Дууны үгийг анхааралтай сонсож, зурагт тулгуурлан ярилцана. (2) https://youtu.be/3PnRxwdqAX4?si=PbKXwZNAyLRocqbN	- Юуны тухай дуу вэ? - Дуугаар юуг илэрхийлсэн бэ?
III	Үдийн хоол (Хоолны цэс - Хүнсний ногооны ач тус) - Хооллохын өмнө хүнсний ногооны ач тусыг таниулахад чиглэсэн яриаг хоол зүйч, тогооч, сургуулийн эмчтэй хамтран зохион байгуулна. (3) (Өдрийн хоолны зурагт цэсийг ашиглана.) - Үдийн хоол иднэ.	- Өнөөдрийн хоолонд ямар ямар ногоо байна вэ? - Эдгээр ногооны нэрийг хэлж чадах уу? - Ямар өнгөтэй байна вэ? - Чи аль ногоог өмнө нь идэж үзсэн бэ? - Өсөж, эрүүл байхад хүнсний ногоо яагаад хэрэгтэй вэ? - Өнөөдрийн хоолноос аль ногоог чи мэдэх вэ? - Хоолоо идэхдээ ямар дэг баримтлах вэ?

IV	* Зургийг ажиглаад, тусч хүүхдийг сонгоорой. - Зургийг анхааралтай ажиглаж хэнд, яаж тусалж байгааг болон яагаад туслаагүй талаар ярилцаж, тусч хүүхдийг сонгоно. * Багшийн зааврыг дагаад хийгээрэй. - Хэнд тусалж байснаа зураарай. - Зурсан зургаа ангийнхандаа тайлбарлана.	- Чиний бодлоор тусч хүүхэд гэж ямар хүүхдийг хэлэх вэ? - Аль хүүхэд тусч вэ? - Хүүгийн/Охины хийсэн үйлдэл зөв үү? Буруу юу? Яагаад? - Хэнд тусалж байсан бэ? - Юу хийж тусалсан бэ? Зураарай.
----	--	---

Анхаарах зүйл:

- “Надад туслаарай”, “Би чамд тусалъя”, “Баярлалаа” үг хэллэг хэрэглэж, хэвшүүлнэ.
- Өөрөө хийж чадахгүй үед бусдаас эелдгээр тусламж хүсэх нь зөв гэдгийг ойлгуулна.
- Ярих, дүрд тоглох, зураг зурах, тайлбарлахдаа хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан нэмэлт дэмжлэг үзүүлнэ.
- Бусдад тусална гэдэг нь өмнөөс нь бүхнийг хийх биш, хэрэгтэй үед нь дэмжих, хамтрах гэдгийг ойлгуулна.
- Бусдад туслах нь тусч хүүхдийн сайн зан чанар гэдгийг үйл ажиллагаагаар дамжуулан ойлгуулна.
- I ангийн монгол хэлний бусдын яриаг сонсож ойлгох, асуултад хариулах, өөрийн санаа, хэрэгцээг илэрхийлэх; нийгмийн ухааны бусадтай эерэг харилцах, тусламж хүсэх, туслах, хамтран оролцох; хөгжим, дүрслэх урлагийн дууны утгыг сонсож илэрхийлэх, санаагаа зургаар дүрслэхтэй холбоотой суралцахуйн үр дүн, чадварыг зураг ажиглан ярилцах, дүрд тоглох, дуулах, хэнд хэрхэн туслахаа зургаар илэрхийлж тайлбарлах үйл ажиллагаагаар дэмжинэ. Үүгээр харилцах, хамтран ажиллах, шүүн тунгаах, нийгэм-сэтгэл хөдлөлийн ерөнхий чадамжийг дэмжих бөгөөд эдгээр үр дүнг тухайн өдөр бүрэн эзэмшүүлэх, үнэлэх зорилго тавихгүй.

ТУСАЛЪЯ, ТАЛАРХЪЯ

✓ Тусламж хэрэгтэй байгаа хүүхдийг олоорой.



Хамтдаа дуулаарай.




Багшийн чиглүүлэх асуултын дагуу ярилцана. Хэнд ямар тусламж хэрэгтэй болсон, хэн яаж тусалсан талаар ярилцаж, хосоороо дүрийн тоглолт хийнэ.

Зурагт карт ашиглан дууны утгыг ярилцана. Хөгжмийн багштай хамтран “Сайн уу муу юу аль нь вэ хө?” дууг дуулж сурна.

✓ Зургийг ажиглаад, тусч хүүхдийг сонгоорой.



Багшийн зааврыг дагаад хийгээрэй.



Зургийг ажиглан хэн нь тусч сайн хүүхэд, хэн нь бусдад тусалдаггүй хүүхэд болохыг ярилцаж, тусч хүүхдийн хийж байгаа үйлдлийг сонгоно.

Багшийн заавраар хэнд, юугаар туслахаа зургаар илэрхийлнэ.

Жишээ нь Тоглоомоо хурааж тусална гэвэл тоглоом, машин, бөмбөг зурна. Аяга угааж тусална гэвэл аяга, халбага гэх мэт түлхүүр зургаар төлөөлүүлж зуруулаарай..

Би ээждээ тусална гэвэл эмэгтэй хүн зурна. (хүн зурахдаа зураасаар, дүрсээр илэрхийлж болно.)

(1)



(2)




(3)



ЛУУВАН



БАЙЦАЙ



ТӨМС



СОНГИНО



САРМИС



ХҮРЭН МАНЖИН




ӨРГӨСТ ХЭМХ



УЛААН ЛООЛЬ



АМТАТ ЧИНЖҮҮ



ХАШ




ЦЭЦЭГТ БАЙЦАЙ



БРОККОЛИ
(ЦЭЦЭГТ БАЙЦАЙ)



НОГООН ЧИНЖҮҮ



ЦАГААН МАНЖИН



БАЙЦАЙНЫ НАВЧ

СЭДЭВ 10. БИД ХАМТДАА ХИЙЖ ЧАДНА

Өдрийн зорилго: Суралцагч хосоор болон багаар ажиллахдаа өөрт тохирсон үүрэгтэй оролцож, бусдыг сонсох, ээлжээ хүлээх, санаагаа хуваалцах, хэрэгтэй үед тусалж хамтын зорилгод хувь нэмэр оруулдгийг мэднэ.

Хэрэглэгдэхүүн: “Манжин” үлгэрийн зураг, эх эсхүл бичлэг. https://www.youtube.com/watch?v=oj4c4_t8TQU (1); нар, үүл гэх мэт байгалийг илэрхийлэх зурагт карт, ватум цаас (2); цаасан аяга эсвэл ам дөрвөлжин өнгийн цаас (3); баримлын шавар (4); өнгийн цаас, хайч, цавуу, модны загвар зураг (5); эвлүүлдэг зураг (6); нарийн ногоо болон зурагт карт (7)

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт
I	“Манжин” үлгэрийг сонсоод ярилцаарай. - Багш “Манжин” үлгэрийг зураг, ном, бичлэг эсхүл өөрийн яриагаар сурагчдад хүргэнэ. (1) - Үлгэрийн үйл явдлаас дүрүүдийн хийсэн үйлдлийг ярилцана. - Өвгөн манжингаа ганцаараа хурааж чадахгүй байсан учраас бусдаас тусламж хүсэж, хамтдаа хурааж чадсан. Үүгээр дамжуулан “Бид ч бас хамтран ажиллавал ганцаараа хийхэд хүндрэлтэй зүйлийг хамтдаа хийж чадна” гэсэн санааг сурагчдын хариултад тулгуурлан дүгнэнэ. - Төгсгөлд нь өвгөнд туслахаар хэн хэн ирснийг дарааллын дагуу нэрлүүлж болно.	Үлгэрийн зургийг харуулж - Энэ ямар үлгэр вэ? - Та нар энэ үлгэрийг мэдэх үү? - Үлгэрт хэн хэн гардаг вэ? Үлгэр сонсоод/үзээд - Өвгөн яагаад дийлэхгүй байгаа юм бол? - Хэрэв өвгөн ганцаараа татсаар байсан бол манжинг хурааж чадах байсан болов уу?
II	*Багшийн зааврын дагуу хосоор ажиллаарай. - Зургийг ажиглаад, хүүхдүүд юу хийж байгааг таамаглан ярилцаарай. - Өгсөн картуудаас найзынхаа хэлсэн зурагтай картыг хайж олох тоглоом тоглоно. Тодорхой хугацаанд эхлээд ганцаараа, дараа нь багаар карт цуглуулж, аль тохиолдолд олон карт цуглуулсныг харьцуулж ярилцана. (2) <i>Хэрэглэгдэхүүний хүртээмж, орчин нөхцөлд тохируулан хосоор ажиллах өөр тоглоомыг сонгож болно.</i>	- Чи ганцаараа хэдэн карт цуглуулсан бэ? - Хоёулаа хэдэн карт цуглуулсан бэ? - Аль тохиолдолд олон карт цуглуулсан бэ? Яагаад?

III	Үдийн хоол (Үдийн хоолны цэс- өнөөдрийн хоолонд орсон ногоог танья) - Өмнөх өдрийн үйл ажиллагааг “Өчигдөр бид ямар ногоонуудын талаар ярилцсан билээ?” гэсэн асуултаар сэргээн ярилцана. - Өдрийн хоолны зурагт цэсийг ажиглан, ямар ногоо байгааг нэрлэнэ. - Ногоонуудыг өнгө, хэлбэр, амт зэрэг нэг шинжээр нь харьцуулж ярилцана. Жишээлбэл: “Лууван, байцаа хоёр юугаараа ялгаатай вэ?, Ямар өнгөтэй вэ? гэх мэт” - Үдийн хоолоо иднэ. - Хооллох үеийн дэгийг хэрэгжүүлж, хоолны дараа аяга, хэрэгслээ хураана.	- Өчигдөр бид ямар ногоонуудын талаар ярилцсан бэ? - Өнөөдрийн хоолонд ямар ногоо орсон байна вэ? - Чи ногоог хооронд нь яаж ялган таньсан бэ? - Амт нь ямар санагдав? - Өнөөдөр ямар шинэ ногоо таньсан бэ? - Ногоотой хоол идэх нь бидний биед ямар ач тустай вэ? - Хооллож дуусаад хэрэгслээ яах вэ?
-----	--	---

Анхаарах зүйл:

- Хосоор ажиллах нь багаар ажиллахын эхлэл тул эхлээд хосоор, дараа нь багаар гэсэн зарчмаар ажиллана.
- Багаар ажиллахдаа хүн бүрд ойлгомжтой, хийж чадахуйц нэг үүрэг өгч, бүх гишүүн оролцох нөхцөл бүрдүүлнэ.
- Багуудыг өрсөлдүүлэхгүй.
- Багш “Ингэж хий” гэж заахаас илүү “Яаж хийх вэ?”, “Өөр ямар арга байж болох вэ?”, “Найзынхаа санааг яаж дэмжих вэ?” гэсэн асуултаар чиглүүлнэ.
- Үйл ажиллагааг аль болох цөөн сурагчтай багаар, богино хугацаанд зохион байгуулна.
- Сурагчийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн зурах, наах, барих, байрлуулах, сонгох, тайлбарлах зэрэг оролцооны өөр хэлбэр санал болгоно.
- Хайч, цавуу болон бусад хэрэглэгдэхүүнийг аюулгүй ашиглахыг сануулж, суралцагч өөрөө авч хэрэглээд, буцааж хураах боломжийг бүрдүүлэхийг зорино.
- Үйл ажиллагааны төгсгөлд “Би юу хийсэн бэ?”, “Найз маань юу хийсэн бэ?”, “Бид юуг хамтдаа хийж чадсан бэ?” гэсэн асуултаар чиглүүлж, багийн оролцоог эргэн харах боломж бүрдүүлнэ.
- Үдийн хоолны үеийн хүнсний ногооны тухай ярилцлагыг тухайн өдрийн хоолны бодит цэстэй холбон богино хугацаанд ажиглуулах, нэрлүүлэх, таних үйл ажиллагаанд шингээж хэрэгжүүлнэ.
- I ангийн сургалтын хөтөлбөрт туссан бусдын яриаг сонсох, өөрийн санаа бодлоо илэрхийлэх, ээлжээ хүлээх, хамтран оролцох, үүргээ гүйцэтгэх, асуудлыг хамтран шийдэх чадвар болон шүүн тунгаах, суралцахууд суралцах чадамжийг хос, бүлгийн бодит үйл ажиллагаанд шингээж хэрэгжүүлнэ.

Тухайн өдрийн “Бид хамтдаа хийж чадна” сэдэвт үйл ажиллагааны **IV** болон **V** цагуудад хүүхдүүд багаар ажиллах явцад сургуульд бэлтгэгдсэн байдлын оношлох үнэлгээ хийгдэнэ. Оношлох үнэлгээнд **Багшийн ажиглалтын хуудас №1** ашиглахыг анхаарна уу. Төлөвлөсөн үйл ажиллагааг өөрчлөхгүй хэрэгжүүлээрэй.

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Багшийн чиглүүлэг	Үнэлгээний ажиглах үзүүлэлт
IV	*Багшийн зааврын дагуу багаар ажиллаарай. - Сурагчдыг баг болгон хувааж, баг бүр нэг бүтээл хийх даалгавар өгнө. - Үйл ажиллагааг эхлэхийн өмнө “Бид хамтдаа юу хийх вэ?”, “Хэн юу хийх вэ?” гэсэн 2 асуултаар үүргийг хуваарилна. - Сурагч бүр заавал нэг үүрэгтэй оролцоно. Жишээлбэл, сонгох, барих, зурах, наах, өрөх, байрлуулах, тайлбарлах гэх мэт. - Багууд ажиллаж байх явцад багш шийдлийг шууд хэлж өгөхгүй, “Одоо яах вэ?”, “Найздаа яаж туслах вэ?” гэх мэтээр чиглүүлнэ. Багаар хийж болох жишээ хувилбарууд: 1. Сурагчид нэг нэг зурагт карт сонгон авч, ширээний голд байх ватум цаасан дээр зурна. Сурагч бүрийн зурсан зураг нийлээд нэг бүтээл болно. Хэн хаана зурах талаар хамтдаа ярилцаж, дарааллаа гаргана. (2) 2. Цаасан аяга эсвэл ам дөрвөлжин өнгийн цаасаар цамхаг хийнэ. Тооцоологч, өрөгч, наагч, борлуулагч гэх мэт гишүүдийн үүргийг хуваарилна. (3) 3. Гишүүн бүр баримлын шавраар бүтээл хийнэ. Нэгтгэж багийн бүтээл болгоно. (4)	Багш баг бүрд бүтээл хийх зааврыг танилцуулах Багийн бүтээл урлахдаа суралцагчдад өгөх багшийн чиглүүлэг, үүнд: - Суралцагч бүр өөрт оногдсон үүрэг даалгаврыг хариуцлагатай гүйцэтгэхэд анхаараарай. - Багийн бүтээл хийхэд идэвхтэй оролцоорой. - Багийн бусад гишүүдтэй өөрийн санаа бодлоо солилцоорой. - Бусдыгаа сонсоорой, хүндэтгэлтэй харилцаарай. - Өөрийн ээлжийг хүлээж бусад хүүхдүүдтэй хамтран ажиллаарай. - Багийн гишүүнд тусламж хэрэгтэй бол дуслаарай, багаа дэмжээрэй.	Ажиглагч багш дараах үнэлгээний шалгуурыг баримтлана /Багшийн ажиглалтын хуудас №1-ийг ашиглах/. - Өөрт оногдсон үүрэг, даалгавраа хариуцлагатай гүйцэтгэсэн. - Бүтээлийг хийхдээ идэвхтэй оролцсон. - Багийн гишүүдтэйгээ санал бодлоо солилцсон. - Бусдын санаа бодлыг сонсож хүндэтгэсэн. - Ээлжээ хүлээж хамтран ажиллах дүрмийг мөрдсөн. - Хамтын бүтээлд өөрийн хувь нэмрээ оруулсан. - Бусдад тусалж багаа дэмжсэн.
V	4. Навч хайчилж, модны загварт наана. Багийн гишүүн бүрийн хайчилж наасан навчаар мод бүтнэ. (5) 5. Багийн гишүүд өөрт оногдсон зургуудаа нийлүүлж эвлүүлэн нэг том зураг бүтээнэ. Хэн эхэлж зургаа тавих, өөрийнх нь барьсан зургийн хэсэг хаана орохыг ажиглах, ярилцах, ээлжээ хүлээх байдлаар оролцоно. (6) - Багийн бүтээлээ бусдадаа танилцуулна. * Ангидаа юу хийснээ сонгож, будаарай. - Зураг дээрх хүүхдүүд юу хийж байгааг ажиглан ярилцана. 6. - Өнөөдөр юу хийснээ эргэн санаж, тохирох зургийг будна. Жишээлбэл, Чи өнөөдөр самбар арчсан бол самбар арчиж байгаа хүүхэд болон самбарыг будаарай.		

Манжин үлгэрийг сурагчдад сонгох/үзүүлэх/ярьж өгөх байдлаар хүргэнэ. Энэ үлгэрээр дамжуулж хамтдаа хийх, багаар ажиллахын давуу талыг ойлгоно.

БИД ХАМТДАА ХИЙЖ ЧАДНА

"Манжин" үлгэрийг сонсоод, ярилцаарай.



Багшийн зааврын дагуу хосоор ажиллаарай.



Хосоор ажиллах нь багаар ажиллахын эхлэл тул эхлээд хосоор, дараа нь багаар гэсэн зарчмаар явна.

Өгсөн картуудаас найзынхаа хэлсэн зурагтай картыг хайж олох тоглоом тоглоно. Тодорхой хугацаанд эхлээд ганцаараа, дараа нь багаар карт цуглуулж, аль тохиолдолд олон карт цуглуулсныг харьцуулж ярилцана.

Багшийн зааврын дагуу багаар ажиллаарай.



Ангидаа юу хийснээ сонгож, будаарай.



24

Багаар ажиллахдаа ямар нэгэн үүрэгтэй оролцохоос гадна ангидаа бас үүрэг оролцоотой байдаг, тэр үүрэг нь юу байж болох талаар зурагт тулгуурлан ярилцаж, өнөөдөр ангидаа юу хийсэн тэр үйлийг нь сонгож будуулна. (Зургийг бүтэн будуулах шаардлагагүй.)

Сурагчид сонирхлоороо нэгдэн баг болно. Багийн бүтээл болон ямар үүргээр оролцсоноо бусдад танилцуулна.

БИД ХАМТДАА ХИЙЖ ЧАДНА

Миний оролцоо



Цаасан аяга эсвэл ам дөрвөлжин өнгийн цаасаар цамхаг хийнэ. Тооцоологч, өрөгч, наагч, борлуулагч гэх мэт гишүүдийн үүргийг хуваарилна.

Сурагчид нэг нэг зурагт карт сонгон авч, ширээний голд байх ватум цаасан дээр зурна. Сурагч бүрийн зурсан зураг нийлээд нэг бүтээл болно. Хэн хаана зурах талаар хамтдаа ярилцаж, дарааллаа гаргана.

Гишүүн бүр баримлын шавраар бүтээл хийнэ. Нэгтгэж багийн бүтээл болгоно.



Багийн гишүүд өөрт оногдсон зургуудаа нийлүүлж эвлүүлэн нэг том зураг бүтээнэ. Хэн эхэлж зургаа тавих, өөрийнх нь барьсан зургийн хэсэг хаана орохыг ажиглах, ярилцах, ээлжээ хүлээх байдлаар оролцоно.

Навч хайчилж, модны загварт наана. Багийн гишүүн бүрийн хайчилж наасан навчаар мод бүтнэ.



Багшийн ажиглалтын хуудас №1

Суралцагчийн нэр:..... Ажиглалт хийсэн багшийн нэр:..... Огноо:.....

Үнэлгээний зорилго: Хүүхэд урлан бүтээх үйлээр өөрийн санаа бодлоо бусадтай хуваалцах, бусдыг сонсож хүндэтгэх, үүрэг хуваарилан шийдвэр гаргах, зорилгоо хамтдаа биелүүлэх чадварыг үнэлэхэд чиглэнэ.

№	Шалгуур	Ажиглах үзүүлэлт	3	2	1
1	Үүргээ биелүүлж буй байдал	Өөрт оногдсон үүргээ хариуцлагатай гүйцэтгэсэн	☐	☐	☐
2	Хамтын шийдвэр гаргах чадвар	Багийн гишүүдтэй хамтран ярилцаж шийдвэр гаргасан	☐	☐	☐
3	Өөрийн ээлжийг хүлээж бусдыг хүндэтгэх байдал	Ээлжээ хүлээж, бусдыг хүндэтгэсэн	☐	☐	☐
4	Багт тусламж, дэмжлэгтэй оролцоо	Бусдад тусалж, хамтын ажиллагааг дэмжсэн	☐	☐	☐
5	Зорилготой багийн ажиллагаа	Нэгдсэн бүтээлийн зорилгыг ойлгон ажилласан	☐	☐	☐
6	Өгөгдсөн хугацаанд багтаан үйл гүйцэтгэх байдал	Даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэсэн	☐	☐	☐

Үнэлгээний тайлбар:

- ✓ **3** – Бие даан гүйцэтгэсэн: Үйлдлийг өөрөө зөв гүйцэтгэж, алдаагаа засаж, зөвлөгөөг хэрэгжүүлсэн.
- ✓ **2** – Дэмжлэгтэй гүйцэтгэсэн: Сануулах, чиглүүлэх үед үйлдлийг гүйцэтгэж чадсан. Давтан оролдсон.
- ✓ **1** – Тусламж шаардлагатай: Байнгын тусламж, дэмжлэг шаардлагатай бөгөөд үйлдлийг гүйцэтгэхэд хүндрэлтэй байсан.

Анхаарах зүйл:

- Хүүхдийг үйлдэл хийж байхад ямар нэгэн тусламж үзүүлэхгүй өөрөө оролдох боломж өгөх
- Хүүхдүүдийг харьцуулсан дүгнэлтийг хэлэхгүй байх
- Үйлдлийг гүйцэтгэх боломжит хугацааг өгөх, яаруулахгүй байх
- Зааврыг тодорхой өгөх, олон зааврыг нэг дор өгөхгүй байх

(2)

ҮГИЙН КАРТУУД



алим



банана



лууван



баавгай



ном



харандаа



бөмбөг



машин



байшин



мод



аяга



сандаг



нохой




муур



эрвээхэй



цэцэг



өвөө



эмээ




охин



нохой




муур




хулгана



загас



бөмбөг



тоглоомын завь

III ДОЛОО ХОНОГ. БИ СУРГУУЛИЙН СУРАГЧ

Энэ долоо хоногт суралцагчид нэгээс хоёр алхамтай зааврыг дагаж мөрдөх, хэрэглэгдэхүүнээ сонгох, ашиглах, буцааж хураах зэрэг өдөр тутмын үйл ажиллагааг бие даан гүйцэтгэж сурахад нь дэмжлэг үзүүлнэ.

СЭДЭВ: 11. МИНИЙ ЦҮНХ

Энэ өдрийн IV, V цаг нь сургуульд бэлтгэгдсэн байдлыг оношлоход чиглэсэн үйл ажиллагаа байна.

Өдрийн зорилго: Хичээлийн хэрэгслээ цүнхний тасалгаанд төрөлжүүлэн, эмх цэгцтэй хийж сурна.

Хэрэглэгдэхүүн: Сүү, сүүн бүтээгдэхүүний зураг (1);

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт (жишээ)
I	*Сурагчийн цүнхэнд байх хичээлийн хэрэгслийг сонгож, будаарай. - Зургийг ажиглаад, юу юу байгааг нэрлэнэ. - Зургаас цүнх болон хичээлийн хэрэгслийг будна. Зургийг будахдаа илүү гаргахгүй, цэвэр, бүтэн будуулахад багш анхаарч, тусламж хэрэгтэй сурагчдад дэмжлэг үзүүлнэ. Сурагчид цүнхэнд байгаа хичээлийн хэрэгслээ гаргана. - Чиний цүнхэнд ямар хичээлийн хэрэгсэл байна вэ? гэх мэт жишээ асуултын дагуу ярилцана.	- Зураг дээр юу юу байна вэ? - Чиний цүнхэнд ямар хичээлийн хэрэгсэл байна вэ? - Харандаа юунд хэрэгтэй вэ? - Баллуурыг хэзээ ашиглах вэ? - Хайч, цавуу зэрэг хэрэгслийг яаж аюулгүй авч явах вэ?
II	Цүнхэндээ цэгцэлж хийе. - Ширээн дээр гаргаж тавьсан хичээлийн хэрэгслээ цүнхэндээ хэрхэн, яаж хийх талаар ярилцана. Чиний цүнх хэдэн тасалгаатай байна вэ? Энэ тасалгаанд юу хийвэл тохиромжтой вэ? Үзэг, баллуураа цүнхэндээ шууд хийх үү? Хаана хийвэл зөв бэ? гэх мэт асуултаар чиглүүлнэ. - Үзэг → үзгийн сав → цүнх гэх мэт дарааллаар хичээлийн хэрэгслээ цэгцэлнэ. *Цүнхэнд дараах зүйлсийг ангилж хийгээрэй. - Зургийг ажиглаад, өгсөн зүйлсийг цүнхний тасалгаанд хэрхэн, яаж ангилж хийх талаар ярилцаж, тохирох тасалгаатай нь холбоно.	- Чиний цүнх хэдэн тасалгаатай вэ? - Том тасалгаанд ямар зүйл хийвэл тохиромжтой вэ? - Жижиг тасалгаанд юу хийж болох вэ? - Үзэг, харандаа, баллуураа хаана хийх вэ? - Яагаад үзэг, харандаагаа шууд цүнхэнд хийхгүй вэ?
III	Үдийн хоол (Үдийн хоолны цэс - Сүү, сүүн бүтээгдэхүүн) *Аль нь эрүүл мэндэд тустайг ярилцаарай. - Зургийг ажиглаад, ямар төрлийн уух зүйлс байгааг нэрлэнэ. Аль нь бидний эрүүл мэндэд тустай болохыг сонгож, холбоно. Сурагч тус бүрийн сонгосон уух зүйлийн ач тусыг ярилцана. Зурагт харуулсан “сүү,	- Ямар төрлийн уух зүйлс байна вэ? - Аль нь сүү, сүүн бүтээгдэхүүн бэ? - Аль уух зүйл нь эрүүл мэндэд тустай вэ? - Сүү уух нь биед ямар хэрэгтэй вэ? - Чи сүү, тараг, айргаас алийг нь ууж үзсэн бэ?

жүүс, ус, хийжүүлсэн ундаа” эдгээрээс сүү, сүүн бүтээгдэхүүний ач тусыг тайлбарлаж өгнө.	- Сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэхийн ач тус юу вэ?
--	--

Анхаарах зүйл:

- Хичээлийн хэрэгслийг нэрлүүлэхээс илүү зориулалтаар нь сонгох, хэрэглэх, ангилах, хэрэглэсний дараа хураах бодит үйлийг хийлгэнэ.
- Хайч, цавуу, шугам зэрэг хэрэгслийг хэрхэн аюулгүй хэрэглэх, дамжуулах, цүнхэндээ хийхийг багш дагуулан хийлгэнэ.
- Сургалтын хөтөлбөр дэх монгол хэлний 1.1а Богино зааврыг ойлгон үйлдлээр илэрхийлэх чадвар; 1.4б Өдөр тутамд түгээмэл хэрэглэгдэх үгийг мэдэж хичээлийн хэрэгслээ нэрлэж, зориулалтыг тайлбарлах чадвар; Математикийн 1.4а Юмсыг нэг шинжээр ангилах, зориулалтаар нь ялган байрлуулах чадвар; 1.2б Юмсын байршлыг тодорхойлох чадвар; Эрүүл мэндийн 1.1а Өсөж, том болоход хэрэгтэй зүйлсийн талаарх ойлголтыг ярилцлагаар урьдчилан төсөөлүүлнэ.
- Сургуулийн өмнөх боловсролд эзэмшсэн “сонголт хийх, ангилах, эд зүйлээ хураах, эхэлснээ дуусгах” дадлыг сургуулийн бодит орчинд бататгаж байна.

IV, V цаг дээр сургуульд бэлтгэгдсэн байдлыг оношлох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Зорилго: Суралцагч нь юмсыг ажиглан тоолох, харьцуулах, ангилах, зүй тогтлыг илрүүлэх замаар асуудлыг шүүн тунгааж шийдвэрлэх, өөрийн санаа, шийдлийг бүтээлчээр илэрхийлэх чадамжийг тодорхойлох.

Зөвлөмж: Багш ажлын хуудасны даалгавар бүрийг танилцуулж хэрхэн гүйцэтгэх талаар чиглүүлнэ. Суралцагч эхний таван даалгаврыг IV цагт тус бүр 5 минут ажиллахаар тооцно. Хамгийн сүүлийн (өгсөн дүрсүүдээр зохиомж хийгээрэй, зохиомжоо баяжуулан зураарай) даалгаврыг V цагт 30 минутын хугацаанд гүйцэтгэнэ.

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Багшийн чиглүүлэг	Үнэлгээний шалгуур
-----	---------------------------	-------------------	--------------------

IV	*Тоолоод, тохирох тоог бичээрэй. *Богиноос урт руу зөв дараалуулсан зургийг сонгоорой. *Ажиглаад, дараагийн гурван дүрсийг зураарай. *Орхисон тоог нөхөж бичээрэй. *Дүрсүүдийг ашиглан зүй тогтол зохиогоорой. - Даалгавар бүрийг 5 минутад гүйцэтгэнэ. - Багшийн заавраар даалгаврыг гүйцэтгэнэ.	- Суралцагчид ширээнд суусан байна. - Эхний даалгаврыг гүйцэтгэсэн, эсвэл 5 минут өнгөрсөн тохиолдолд багш дараагийн даалгаврыг хэрхэн гүйцэтгэхийг тухай бүрд нь суралцагчдад (нийтийн дунд) нэг удаа тайлбарлана. Шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбарыг хэлж болно. - Багшийн дэмжлэг хүссэн суралцагчдад нэмэлт тайлбар өгч, ганцаарчилсан дэмжлэг үзүүлнэ.	- 10 хүртэлх юмсыг оноож тоолдог. - 10 хүртэл цифрийг бичих, тэмдэглэх тоглоом (бөмбөлгийг тоолоод тэнцүү тооны цэг, зураас зурах, зурагт байгаа юмсыг тоолоод тохирох цифрийг бичдэг. - Юмсын хэмжээ (урт, хүнд, багтаамж) нь таамаглан харьцуулдаг. - 10 хүртэлх тооны дарааллаас орхигдсон 1-2 тоог олдог. - Юмсыг ашиглан давтамж үүсгэж, шинэ загвар гаргаж бүтээл хийдэг. - Дүрс, биетийг нэрлэх, ангилах, харьцуулах, зүй тогтлыг таних, үргэлжлүүлэх зохиомжилдог.;
V	*Өгсөн дүрсүүдээр зохиомж хийгээрэй. Зохиомжоо баяжуулан зураарай. - Даалгаврыг 30 минутад гүйцэтгэнэ. - Өгсөн дүрсүүдийг ашиглан зохиомж хийж, баяжуулан зурна.	- Суралцагчдын дэвтэр дэх даалгаврыг хэрхэн ажиллах тухай тайлбарлаж өгнө. - Дүрсээр бүтээсэн зохиомжоо баяжуулан зурахдаа будгийн харандаа, ажиглахыг санал болгоно. - Гэртээ очоод дүрс ашиглан гэр бүлийнхэнтэйгээ зохиомж хийгээрэй.	- Төсөөлөн зохиох, бүтээлчээр сэтгэх, даалгаврыг сонирхож хийдэг. - Өөрийн төсөөлөл, санаачилгаар шинэ зүйл бүтээх, хийх, дахин сайжруулах шинэ санаа гаргах. - Өөрийн санааг янз бүрийн аргаар илэрхийлэх (зургаар, баримлаар гэх мэт);

Даалгаврын гүйцэтгэлийг оноожуулах зөвлөмж

№	Шалгуур	Ажиглах үзүүлэлт	Оноо өгөх аргачлал	Оноо
1	10 хүртэлх юмсыг тоолох; 0-9 хүртэл цифрийг таних; юмсыг нэг нэгээр нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох; хоёр бүлэг юмсыг жишиж харьцуулдаг.	Зурагт байгаа юмыг оноож тоолон, тохирох цифрийг бичих	Тохирох гурван цифрийг бие даан бичсэн.	4
			Тохирох хоёр цифрийг бие даан бичсэн.	3
			Тохирох нэг цифрийг бие даан бичсэн.	2
			Тохирох гурван цифрийг багшийн дэмжлэгтэйгээр бичсэн.	1
			Тохирох цифрийг бичээгүй.	0
2	Хоосон, дундуур, дүүрэн, урт, богино, хүнд, хөнгөнийг	Богиноос урт руу нь зөв дарааллаар	Зөв дараалалд байх зургийг бие даан тэмдэглэсэн.	2
			Зөв дараалалд байх зургийг бие даан тэмдэглэхдээ багшийн дэмжлэг авсан.	1





	таамаглан, туршин харьцуулж тайлбарладаг.	байрлуулсныг олж тэмдэглэх	Зөв дараалалд байх зургийг тэмдэглээгүй.	0
3	Тоглоом, дүрсүүдээр зүй тогтол үүсгэн тайлбарлана.	Зүй тогтлыг ажиглаад асуултын тэмдгийн оронд байх дүрсийг сонгож дугуйлах	Зүй тогтлыг бие даан гүйцэт зөв үргэлжлүүлсэн.	4
			Зүй тогтлыг бие даан үргэлжлүүлэхдээ 1 дүрс эсвэл өнгийг сольсон, эсвэл орхисон.	3
			Зүй тогтлыг бие даан үргэлжлүүлэхдээ 2 дүрс эсвэл өнгийг сольсон, эсвэл орхисон.	2
			Зүй тогтлыг бие даан үргэлжлүүлэхдээ 3 дүрс эсвэл өнгийг сольсон, эсвэл орхисон.	1
			Зүй тогтлыг үргэлжлүүлэхдээ бүх дүрс, өнгийг буруу үргэлжлүүлсэн эсвэл үргэлжлүүлээгүй.	0
4	Юмсын өнгө, дүрс, хөдөлгөөнийг ажиглаж зүй тогтлыг үүсгэж, орхигдсон тоог нөхөж хэлдэг, бичдэг.	Цифрийг ажиглаад орхигдсон тоог нөхөж бичих	Орхигдсон бүх тоог бичсэн.	5
			Орхигдсон тооноос 2 тоог бичсэн.	4
			Орхигдсон тооноос 1 тоог бичсэн.	3
			Орхигдсон тооноос 2 тоог багшийн дэмжлэгтэй бичсэн.	2
			Орхигдсон тооноос 1 тоог багшийн дэмжлэгтэй бичсэн.	1
			Орхигдсон тоог бичээгүй.	0
5	Өнгө, хэлбэр, хэмжээгээр(улаан, улаан-шар, шар, улаан дугуй, хөх, дөрвөлжин, улаан дугуй)	Дүрсүүдийг ашиглан зүй тогтол зохиох	Зүй тогтлыг гурван удаагийн давтамжтай бие даан зохиосон.	5
			Зүй тогтлыг хоёр удаагийн давтамжтай бие даан зохиосон.	4
			Зүй тогтлыг нэг удаагийн давтамжтай бие даан зохиосон.	3
			Зүй тогтлыг нэг удаагийн давтамжтай зохиосон.	2
			Зүй тогтлыг зохиохдоо багшийн дэмжлэг авсан.	1
			Зүй тогтлыг зохиохдоо багшийн дэмжлэг авсан амжилтгүй.	0
6	Дүрс, биетийг ашиглан шинэ бүтээл хийх, төрөл бүрийн юмсыг ашиглан загвар зохиомжилж тайлбарладаг.	Дүрсүүдийг ашиглан зохиомж хийгээд, баяжуулан зурах	Бүх дүрсүүдийг ашиглан зохиомж хийж, баяжуулан зурсан.	5
			Бүх дүрсүүдийг ашиглан зохиомж хийж, баяжуулан зураагүй.	4
			Дүрс ашиглан зохимж хийж, баяжуулан зурахдаа багшийн дэмжлэг авсан.	3
			Зарим дүрсүүдийг ашиглан зохиомж хийж, баяжуулан зурсан.	2
			Зарим дүрсүүдийг ашиглан зохиомж хийж, баяжуулан зураагүй.	1
			Зохиомж хийгээгүй, баяжуулан зураагүй.	0
Нийт оноо				25

Анхаарах зүйл:

- Даалгаврын заавар, дараалал, хугацааг ижил нөхцөлөөр өгч, бүх суралцагчийг нэгэн зэрэг эхлүүлж, дараагийн даалгаварт нийтээр шилжүүлнэ.

- Зааврыг товч, нэг утгатай өгнө; шаардлагатай бол дахин уншиж болох боловч зөв хариу, гүйцэтгэх арга руу чиглүүлэхгүй.
- Суралцагчид эхлээд бие даан оролдох боломж олгож, өмнөөс нь хийх, хариуг хэлэх, зөв сонголтыг заахгүй.
- Ялгаатай хэрэгцээтэй суралцагчид тохирсон дэмжлэгийг хариунд нөлөөлөхгүй байдлаар үзүүлж болно.
- Багш үзүүлсэн дэмжлэгийг тэмдэглэж, ялгаж баримтжуулна.
- Суралцагчийг яаруулахгүй, бусадтай харьцуулахгүй, “чадсан/чадаагүй”, “сайн/муу” гэж шошголохгүй.
- Алдаа гаргасан үед шууд засахгүй; дахин ажиглах, бодох боломж олгож болох ч хариуг илт чиглүүлэхгүй.
- Үнэлгээний үр дүнг эрэмбэлэхэд бус, ямар мэдлэг, чадвар төлөвшсөн, хаана нэмэлт дэмжлэг шаардлагатайг тодорхойлоход ашиглана.
- Үнэлгээний өмнө ажлын хуудас, харандаа, хайч, суудлын зохион байгуулалт, дэмжлэг үзүүлэх хүний үүргийг урьдчилан бэлтгэнэ.
- IV–V цагт багшийн дэмжлэгийг багасгаж, суралцагчийн бие даасан гүйцэтгэлийг ажиглах нь үндсэн зорилго байна.

(1)



МИНИЙ ЦҮНХ



Сурагчийн цүнхэнд байх хичээлийн хэрэгслийг сонгож, будаарай.



Зурагт өгсөн зүйлсийг нэрлэнэ. Цүнх болон хичээлийн хэрэгслийг олж, будна.

Цүнхний загварыг ажиглаад, өгсөн зүйлсийг цүнхний тасалгаанд хэрхэн, яаж ангилж хийх талаар ярилцаж, тохирох тасалгаатай нь холбоно.



Цүнхэнд дараах зүйлсийг ангилж хийгээрэй



Аль нь эрүүл мэндэд тустайг ярилцаарай.



Зургийг ажиглаад, ямар ямар төрлийн уух зүйлс байгааг нэрлэнэ. Аль нь бидний эрүүл мэндэд тустай бол? Яагаад? гэсэн асуултын дагуу ярилцаж, тохирох зурагтай нь холбоно. Сүү уухын ач тусын талаар ярилцана.




Тоолоод, тоог бичээрэй.



Зургийг ажиглаад цавуу, харандаа, ном тус бүр хэдэн ширхэг байгааг тоолоод тохирох тоог бичнэ.

Зургийг ажиглаад богиноос урт руу зөв дараалуулсан зургийг сонгож өмнөх дугуй дүрсийг будаж тэмдэглэнэ.

Богиноос урт руу зөв дараалуулсан зургийг сонгоорой.



Зургийг ажиглаад дараагийн тохирох гурван дүрсийг зурж, будна.



Ажиглаад, дараагийн гурван дүрсийг зураарай.



Тоог ажиглаад, 10 хүртэлх тоон дарааллаас орхигдсон тоог цэгийн оронд нөхөж бичнэ.



Орхисон тоог нөхөж бичээрэй.

..., 2, 3, ..., 5, ..., 7, ..., ..., 10



Дүрсүүдийг ашиглан зүй тогтол зохиогоорой.



Өгсөн дүрсүүдээр зохиомж хийгээрэй. Зохиомжоо баяжуулан зураарай.



Дүрсүүдийг ашиглан зүй тогтол зохионо. Зүй тогтлын давтамж нь(гурван дүрс нийлээд нэг давтамж) 2-оос дээш байна.

Дүрсүүдийг ашиглан зохиомж хийнэ. Дараа нь зохиомжоо баяжуулан зурна.

СЭДЭВ 12. СОНСООД ДАРААЛЛААР НЬ ХИЙЕ

Энэ өдрийн I, IV цаг нь сургуульд бэлтгэгдсэн байдлыг оношлоход чиглэсэн үйл ажиллагаа байна.

Өдрийн зорилго: Суралцагч сонссон шүлэг, богино зааврын агуулгыг ойлгож, үйл явдал, үйлдлийг зөв дараалуулан сонгож, зааврын дагуу гүйцэтгэнэ.

2 болон 3 дугаар цагийн хэрэглэгдэхүүн: Дасгалын зурагт карт (1); тухайн үдийн хоолны зурагт цэс (2)

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт (жишээ)
II	* Дагаад хийгээрэй. Энэ үйл ажиллагааг биеийн тамирын багштай хамтран зохион байгуулна. - 1 алхамт заавар: “Гараа өргөөрэй”, “Хоёр удаа алга ташаарай”, “Баруун тийш нэг алхам хийгээрэй” гэх мэт. Сурагчид зааврын дагуу хийнэ. - 2 алхамт заавар: “Гараа дээш өргөөрэй. Дараа нь хоёр гараа хажуу тийш дэлгээрэй”, “Нэг удаа алга ташаарай. Дараа нь суугаарай” гэх мэт заавар өгнө. Сурагчид зааврын дагуу хийнэ. Шаардлагатай бол багш дагуулан хийлгэнэ. - Багш 3–4 хөдөлгөөнт дасгалын зурагт карт багуудад өгнө. (1) - Сурагчид картыг ажиглаж, ямар дарааллаар хийхээ ярилцана. - Баг бүрээс нэг сурагч картыг үзүүлж, нөгөө сурагч хөдөлгөөнийг амаар товч зааварлана. Бусад сурагч тухайн дарааллыг дагаж гүйцэтгэнэ. Дараа нь багууд картаа сольж, давтан хийнэ. - “Ямар зааврыг дагахад хялбар байсан бэ?” гэх мэт асуултын дагуу ярилцана. - Заавар өгөхдөө анхааралтай сонсох, тогтоох нь дасгалыг зөв хийхэд тусалдаг болохыг ойлгоно.	- Багш юу гэж хэлсэн бэ? Ямар заавар өгсөн бэ? - Ямар хөдөлгөөн хийсэн бэ? - Хоёр хөдөлгөөний алийг нь эхэлж хийсэн бэ? - Зааврын аль хэсгийг санахад хэцүү байсан бэ? - Найзынхаа өгсөн зааврыг ойлгосон уу? Юу нь ойлгомжтой байсан бэ? - Бусдын зааврыг сонсох хэрэгтэй юу? - Чи өөрийн зохиосон дасгалын дарааллыг бусдад ойлгомжтой хэлж чадсан уу?

III	Үдийн хоол (Үдийн хоолны цэс- сүү, сүүн бүтээгдэхүүн) - Өмнөх өдрийн үйл ажиллагааг эргэн сануулж, 1–2 суралцагчаар яриулна. - Өнөөдрийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүн байгаа эсэхийг ярилцана. - Сүү, сүүн бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө сав, баглаа боодол бүтэн, цэвэр байгаа эсэхийг шалгана. (Үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүн орсон, ороогүйг үл харгалзан мэдээллийг өгнө.) - Үдийн хоол идэхийн өмнө аяга, халбагаа цэвэр эсэхийг шалгах, зөв суух, асгахгүй уух/идэх, хэрэглэсний дараа хоолны хэрэгслээ зөв хураах дарааллыг бодитоор хийлгэнэ.	- Сүү, сүүн бүтээгдэхүүнийн ач тус юу вэ? - Өнөөдрийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүн байна уу? - Сүүгээ уухын өмнө юуг шалгах вэ? - Савыг онгойлгож чадахгүй бол яах вэ? - Сүүгээ ууж дуусаад сав, аягаа хаана тавих вэ? - Сүүгээ асгасан бол хэнд хандах вэ? - Өнөөдөр чи үдийн хоолны ямар дэгийг баримталсан бэ?
-----	--	---

Анхаарах зүйл:

- 3–4 хөдөлгөөнт дасгалын зурагт картыг бүх сурагч ижил хэмжээнд гүйцэтгэхийг шаардахгүй.
- Багаар ажиллахдаа бүх сурагчийг хамруулна.
- Хөдөлгөөнт дасгалын өмнө ширээ, сандлын байрлал, сурагч хоорондын зайг тохируулж, аюулгүй орчин бүрдүүлнэ.
- Үдийн хоолны цаг дээр шинэ агуулга заахгүй, өмнөх өдрийн мэдлэгийг өнөөдрийн хоолны цэстэй холбон таних, хэрэглэх, хураах дарааллыг дадлагажуулах байдлаар зохион байгуулна.
- Монгол хэлний зааврыг ойлгож, үйлдлээр илэрхийлэх чадвар; Математикийн үйл явдал, үйлдлийн дарааллыг тогтоох чадвар; Биеийн тамирын хөдөлгөөнийг зааврын дагуу гүйцэтгэх чадвар, мөн харилцах, суралцахууд суралцах, өөрийгөө удирдах ерөнхий чадамжийг дэмжинэ.

Сургуульд бэлтгэгдсэн байдлыг оношлох даалгавар

Зөвлөмж:

- Тухайн цагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг оношлох үнэлгээний зорилгоор хэрэгжүүлж байгаа тул төлөвлөсөн хугацаа, дарааллын дагуу зохион байгуулна.
- Тухайн цагт төлөвлөсөн үйл ажиллагаа болон “Би сурагч боллоо” номд тусгагдсан даалгаврыг агуулга, дараалал, гүйцэтгэх хэлбэрийн хувьд өөрчлөхгүйгээр хэрэгжүүлнэ.
- Багш нь сурагчид даалгаврыг гүйцэтгэхэд шаардлагатай зааврыг төлөвлөсөн дарааллын дагуу өгч, сурагчийн бие даан гүйцэтгэх боломжийг хангана.
- Үнэлгээний үед суралцагчийн гүйцэтгэлд нөлөөлөхүйц тайлбар, чиглүүлэг, зөв хариу өгөхөөс зайлсхийж, ажигласан гүйцэтгэлийг үнэлгээний шалгуурын дагуу тэмдэглэнэ.

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа		Багшийн чиглүүлэг	Үнэлгээний шалгуур
I	Шүлгийг сонсоод, үйл явдлын дарааллыг тогтоох	- Шүлгийг анхааралтай сонсож, үйл явдлыг ойлгоно. - Эхний даалгаврыг зааврыг сонсоод гүйцэтгэнэ. - Хоосон зайд тохирох үйл явдлыг илэрхийлсэн зургийг сонгоно. - Нэг зургийг сонгоод, түүнд тохирсон тайлбарыг хийнэ.	- “Нойрмог туулай” шүлгийг багш 2 удаа уншиж өгнө. Уншихдаа утгат хэсгээр зогсоц хийж, ойлгомжтой тод чанга уншина. Нойрмог туулай (Д. Содномдорж) Нойрмог туулай байж л гэнэ Номоо дэрлээд унтаж гэнэ Сунайж босоод харсан чинь Сургуулийн цаг нь болчихож гэнэ Тог тог тогшсон чинь Тооны хичээл орж байна гэнэ Буурал багш нь гайхаж гэнэ Бусад хүүхдүүд нь инээлдэж гэнэ - Сурагчийн дасгал ажлын эхний даалгаврын зааврыг уншиж өгөөд, даалгаврыг гүйцэтгэх хугацаа өгнө. - Дараагийн даалгаврын зааврыг 2 удаа уншиж өгөөд, хоосон зайд тохирох үйл явдлыг илэрхийлэх зургийг сонгоно гэдгийг тайлбарлан хэлнэ. - Гурав дахь даалгаврын зааврыг уншиж өгнө. Чиглүүлэх асуултыг давтан хэлнэ.	- Шүлгийг сонсоод, тохирох дүрийг сонгох, үйл явдлыг үргэлжлүүлэн ойлгосноо харуулдаг. - Боломжит шалтгааныг сонгож, сонголтоо өөрийн үгээр тайлбарладаг. - Богино зааврыг анхааралтай сонсож ойлгон хэрэгжүүлдэг.
IV	Богино зааврыг сонсоод, бүтээл хийх	- Богино зааврыг сонсоод, бүтээл хийнэ.	- Богино зааврыг багш 2 удаа уншиж өгнө. Зааврыг уншихдаа бүх хүүхдүүдийн анхаарлыг төвлөрүүлж, зааврыг сонсоод, бүтээл хийнэ гэдгийг хэлж өгнө. - Бүтээлээ хийж дуусах хугацаа өгнө. Багшийн уншиж өгөх богино заавар - Нэг дугуй, хоёр гурвалжин дүрс хайчилж аваарай. - Хайчилсан дүрсээр туулайн толгой, чихийг хийгээрэй. - Өөр гурван дүрс сонгон, туулайгаа гүйцээн бүтээгээрэй. - Нүд, ам, хамар нэмэн зураарай.	

Анхаарах зүйл:

- I, IV цагийн даалгаврыг төлөвлөсөн агуулга, дараалал, заавар, гүйцэтгэх хэлбэрийн дагуу хэрэгжүүлж, оношлох нөхцөлийг анги бүрд аль болох ижил байлгана.
- “Нойрмог туулай” шүлэг болон IV цагийн бүтээл хийх зааврыг 2 удаа уншиж өгнө. Уншихдаа утгыг өөрчлөх, нэмэлт тайлбар оруулах, зөв хариуг онцлон хэлэхгүй.
- Даалгаврын зааврыг бүх суралцагч сонссоны дараа бие даан ажиллах хангалттай хугацаа олгоно. Яаруулах, өмнөөс нь хийх, зөв сонголтыг заахгүй.
- Суралцагч даалгаврыг ойлгоогүй тохиолдолд зааврыг давтан хэлж болох боловч “энэ зургийг хараарай”, “энэ зөв” гэх мэт хариу руу чиглүүлэх нэмэлт асуулт, дохио өгөхгүй.
- Хариуг зөвхөн амаар шаардахгүй; сонгох, заах, дугуйлах, хайчлах, наах, тайлбарлах хэлбэрээр илэрхийлэх боломжийг бүрдүүлнэ.
- Хайчлах үйлд дэмжлэг хэрэгтэй суралцагчид дэмжлэг үзүүлж болох боловч ямар дүрс сонгох, хаана байрлуулахыг зааж өгөхгүй.
- Ялгаатай хэрэгцээтэй суралцагчид зориулсан томруулсан материал, тохиромжтой суудал, хэрэглэгдэхүүн зэрэг хариунд нөлөөлөхгүй тохируулга хийж болох бөгөөд үзүүлсэн дэмжлэгийг тэмдэглэнэ.
- Суралцагчийн хариуг “сайн/муу”, “чадсан/чадаагүй” гэж нийтэд хэлэхгүй, бусадтай харьцуулахгүй; зөвхөн үнэлгээний шалгуур, ажиглах үзүүлэлтийн дагуу тэмдэглэнэ.
- 3 дугаар даалгаварт сонголтын шалтгааныг асуухдаа суралцагчийн хариуг өөрийн үгээр хэлэх боломж олгож, хариултын жишээг урьдчилан санал болгохгүй.
- Үнэлгээний үр дүнг суралцагчийг эрэмбэлэхэд бус, сонсож ойлгох, үйл явдлын холбоо тогтоох, шалтгаанаа тайлбарлах, заавар дагах, дүрс таних, зохиомжлох чадварын аль хэсэгт дэмжлэг хэрэгтэйг тодорхойлоход ашиглана.
- Багшийн тэмдэглэлд зөвхөн оноо бус, ямар нөхцөлд бие даан гүйцэтгэсэн, хаана эргэлзсэн, ямар дэмжлэг шаардсан зэрэг ажиглагдсан баримтыг товч тэмдэглэнэ.

Шүлгийг 2 удаа уншиж өгсний дараа даалгаврыг хийх заавар өгнө.
“Зургийг ажиглаад, шүлэгт гарсан туулайг сонгоорой” гэж хэлнэ.
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа өгөөд, өөр тайлбар өгөхгүй.

СОНСООД, ДАРААЛЛААР НЬ ХИЙЕ

✓ Шүлэгт гарсан туулайг сонгоорой.



✂ Шүлгийг сонсоод үйл явдлын дараалалд тохирох зургийг 47 дугаар нүүрнээс сонгон наагаарай.



✓ Зургаас нэгийг сонгоод, туулай яагаад нойрмоглогсныг тайлбарлаарай



Эхний даалгаврыг гүйцэтгээд дууссаны дараа зааврыг өгнө.
“Зургийн үйл явдлыг ажиглаарай. Шүлэгт гарсан дарааллыг бодоод, тохирох үйл явдлыг хайчлаад наагаарай” гэж хэлнэ.

- Хайчтай ажиллах заавар өгөөрэй.
- Хайчилж чадахгүй байгаа хүүхдэд дэмжлэг үзүүлээрэй.

Дасгалыг дагаад хийгээрэй.



Багшийн зааврыг сонсоод, ажилл

Эдгээр хөдөлгөөнүүдийг багш эхлээд 1 хөдөлгөөн хийх, дараа нь 2 хөдөлгөөнийг дараалуулан хийх зааврыг амаар өгнө.

Ингэхдээ “эхлээд ..., дараа нь” гэсэн форматаар зааварчилгаа өгнө. Аман зааврыг ойлгохгүй бол сурагчийн дэвтрээс хөдөлгөөнийг харах, шаардлагатай бол багш туслах, биеэр үзүүлж болно.

Бүтээл хийх заавар, дарааллыг 2 удаа уншиж өгнө.

Дараа нь: “Дүрсээ зааварт гарсны дагуу зөв сонгон наагаарай” гэж хэлнэ.

Даалгаврыг гүйцэтгэх хугацаа өгөөд, өөр тайлбар өгөхгүй. Хайчтай ажиллах заавар өгөөрэй. Хайчилж чадахгүй байгаа хүүхдэд дэмжлэг үзүүлээрэй.

Хоёр дахь даалгаврыг хийж дууссаны дараа зааврыг өгнө.

“Зургийг ажиглаарай. “Туулай яагаад нойрмоглогсон бол? Туулайны нойр яагаад хүрсэн бол? Чамд ийм зүйл тохиолдож байсан уу? гэсэн асуултад тохирох хариултыг сонгоорой” гэж хэлнэ.

Хариултын тайлбарыг сонгоод дууссаны дараа хүүхэд нэг бүрээс асууж, ажиглалтыг хуудсыг бөглөнө.

Багшийн ажиглалтын хуудас №2

Даалгавар. 3 Туулай яагаад нойрмоглосон байж болохыг зургаас сонгоод, өөрийн үгээр тайлбарлах.

Суралцагчийн нэр: _____ Ажиглалт хийсэн багшийн нэр: _____ Огноо: _____

№	Үнэлгээний шалгуур	Ажиглах үзүүлэлт	3	2	1
1.	Сонголтоо тайлбарлан ярьсан.	Сонгосон зургийг нэрлэж, яагаад сонгосноо тайлбарладаг.	☐	☐	☐
1.	Үйл явдлыг төсөөлж, зохиож ярьдаг.	Шалтгааныг тайлбарлахдаа өөрийн туршлага, бодит амьдралтай холбон төсөөлж тайлбарладаг.	☐	☐	☐
2.	Өөрийн санааг ойлгомжтой илэрхийлдэг.	Санаагаа бүтэн өгүүлбэрээр ойлгомжтой илэрхийлдэг.	☐	☐	☐


Оношлох үнэлгээний даалгаврын гүйцэтгэлийн оноожуулах аргачлал

№	Шалгуур	Ажиглах үзүүлэлт	Оноо өгөх аргачлал	Оноо
1	Шүлгийг анхааралтай сонсож, зурагтай холбон ойлгодог	Шүлэгт гарсан туулайг дүрсэлсэн зургийг сонгох	Номоо дэрлэн унтаж буй туулайг сонгосон бол	2
			Унтаж буй туулайг сонгосон бол	1
			Бүх хариултыг сонгосон бол	0
2	Шүлгийн үйл явдлыг дарааллыг ойлгон, холбоо хамаарлыг олдог.	Туулай хийсэн дараагийн үйлдлийг олж сонгох	Хаалга тогшиж байгаа зургийг сонгосон бол	2
			Хүүхдүүд инээгээд туулай үүдэнд зогсож байгаа зураг сонгосон бол	1
			Багшийн хажууд зогсож буй туулайг сонгосон бол	0
3	3.1 Сонгосон зургийг нэрлэж, шалтгаанаа тайлбарладаг.	Сонгосон зураг нь шүлэгтэй хэрхэн холбоотойг энгийн	Сонгосон зурагтаа тулгуурлан “Ном уншаад оройтож унтсан эсвэл утас үзээд оройтож унтсан” гэх мэтээр шалтгааныг өөрийн үгээр тодорхой тайлбарласан.	2
			Сонгосон зурагт тулгуурлаагүй ч оройтож унтаад нойрмоглосон гэх утга санааг гарган тайлбарласан.	1

		өгүүлбэрээр тайлбарлан ярих	Туулай хичээлээсээ хоцорсон, хүүхдүүд шоолсон гэх мэтээр асуултад хамааралгүй хариулт хэлсэн бол	0	
4	3.2 Өөрийн туршлага, бодит амьдралтай холбон төсөөлж тайлбарладаг.	Ижил төстэй үйл явдал ярих	Туулайн явдал болон өөрт тохиолдсон явдлын ижил төстэй талыг зөв тодорхойлж ярьсан.	2	
			Туулайн явдалтай төстэй өөрийн туршлагыг хэлсэн боловч ижил төстэй байдлыг бүрэн тайлбарлаагүй.	1	
			Туулайн явдал болон өөрийн туршлагын холбоо, ижил төстэй байдлыг хэлж чадаагүй, эсвэл хамааралгүй хариулсан.	0	
	3.3 Санаагаа бүтэн өгүүлбэрээр ойлгомжтой илэрхийлдэг.	Сонгосон зурагт тулгуурлан санаагаа илэрхийлэхдээ бүтэн өгүүлбэрээр ярих	Санаагаа бүтэн өгүүлбэрээр ойлгомжтой илэрхийлсэн.	2	
			Санаагаа холбоо үг эсвэл богино өгүүлбэрээр илэрхийлсэн.	1	
			Санаагаа илэрхийлж чадаагүй эсвэл нэг үгээр/ хамааралгүй хариулт өгсөн.	0	
		4.1 Зааврыг сонсож, дарааллаар зөв гүйцэтгэдэг.	Багшийн өгсөн зааврыг сонсоод, дүрсийг сонгох	Зааврыг дагуу туулайн толгой, чихийг зөв бүтээсэн бол	2
				Зааврыг дагуу туулайн толгой, чихийг зөв бүтээсэн ч өөр 3 дүрс сонгоогүй бүх дүрсийг хэрэглэсэн бол	1
				Туулай бүтээсэн хэдий ч заавартай тохирохгүй бол	0
4.2 Зааварт өгсөн дүрсүүдийг зөв сонгодог.		Дүрсийг зөв таних	Нэг том дугуй, хоёр урт гурвалжин зөв сонгосон бол	2	
			Жижиг дугуй, 2 гурвалжин сонгосон бол	1	
			Зааварт өгсөн дүрсийг зөв сонгоогүй бол	0	
4.3 Дүрсүүдийг өөрийн санаагаар зохиомжлон зурдаг.		Дүрсүүдийг зохиомжлон туулай бүтээж, наах	Дүрсүүдийг зөв зохиомжлон туулай бүтээж нэмэлт зураас, будаг хэрэглэсэн бол (өөрийнхөөрөө зохиомжлох, өвөрмөц байдлыг харгалзах)	2	
			Зааварт өгсөн дүрсээр туулай бүтээсэн хэдий ч нэмэлт зураас, будаг хэрэглээгүй бол	1	
			Дүрсүүдээр хэрэглэн ямар нэгэн зохиомж хийх оролдлого хийгээгүй бол	0	
Нийт оноо				16	

Анхаарах нь: Гуравдугаар даалгаврын ажиглалтын хуудсыг оноожуулахдаа хүснэгтэд өгөгдсөн **3.1, 3.2, 3.3** гэдгийг харах бөгөөд үр дүнг системд 3 дугаар даалгавар хэсэгт шивж оруулна.

(1)



СЭДЭВ 13. ӨНӨӨДӨР ЮУ ХИЙХ ВЭ?

Өдрийн зорилго. Өдөр бүр хийдэг үйл явдлын дарааллыг ярилцаж, өөрийн өдрийн дэглэмээ бусдад танилцуулж, өдрийн дэглэмийн ач тусыг ойлгоно.

Хэрэглэгдэхүүн: Нэг өдрийн үйл явдлыг харуулсан зурагт карт (1); дарааллыг илэрхийлсэн тэмдэглэгээний зурагт карт (2); цахим контент (3); мах, махан бүтээгдэхүүний зурагт карт (4)

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт (жишээ)
I	*Өөрийнхөө өдрийн дэглэмийг найздаа яриарай. - Сурагчийн нэг өдрийн дэглэмийг харуулсан зурагт хуудсыг ажиглаж, хүү хаана, юу хийж байгааг ярилцана. (1) - Бэлтгэсэн зурагт картаас сурагч өөрийнхөө өдөр тутам хийдэг үйлийг сонгон “Өглөө би...”, “Дараа нь...”, “Сургуульдаа...”, “Орой нь...” гэсэн тулгуур үг ашиглан ширээний найздаа өдрийн дэглэмийг ярьж өгнө.	- Өглөө босоод хамгийн түрүүнд юу хийдэг вэ? - Сургуульдаа ирэхээс өмнө юу хийдэг вэ? - Гэртээ хариад юу хийдэг вэ?
II	Өөрт тустай үйлдлүүдийг сонгоорой. - Зургийг ажиглаад, юу ойлгосноо бусдадаа танилцуулна. - Багш сурагчдаар эрт унтсан болон унтаагүй, хоцролгүй ирсэн болон хоцорч ирсэн зургуудыг харьцуулан ажиглуулж, асуултаар чиглүүлэн ярилцана. - Эрт унтах болон орой унтахын аль нь өөрт тустай болохыг сонгож, тэмдэглэнэ.	- Хүү яагаад хичээлдээ хоцорч ирсэн юм бол?, Яагаад хоцроогүй эрт ирсэн бол? гэх мэт асуултаар чиглүүлнэ. - Аль хүүхэд эрт унтаж амарсан байна вэ? - Аль хүүхэд оройтож унтсан байна вэ? - Орой унтахын өмнө утас, таблет удаан үзэхийн оронд юу хийж болох вэ?
III	Үдийн хоол (Үдийн хоолны цэс – мах, махан бүтээгдэхүүн) - Үдийн хоолонд орсон бүтээгдэхүүнийг нэрлэнэ. - Мах, махан бүтээгдэхүүний ач тусыг ярилцана. (4)	- Аль хоолонд мах орсон байна вэ? - Мах идэх нь бидний биед ямар хэрэгтэй вэ?
IV	https://medle.mn/additionallesson/2/261/100004547145612/play “Өдрийн дэглэмийн ач тус” аудио контентыг сонсож, хосоор ярилцана. (3) *Хичээл эхлэхэд бэлэн сууж буй хүүхдийг сонгоорой. - Сурагчдын царайны хувирал, ширээн дээрх эд зүйлсийг харьцуулан ажиглана. - Аль хүүхэд хичээл хийхэд бэлэн байгааг сонгож, тэмдэглэнэ.	- Аль хүүхэд хичээл хийхэд бэлэн байна вэ? - Яаж мэдсэн бэ? - Ангидаа тоглоом авчирч болох уу?

V	*45 дугаар нүүрэнд байгаа зургийг хайчилж, зөв дараалаар наагаарай. - 45 дугаар нүүрэнд байгаа зургийг хайчилна. - Хайчилсан зургаа ажиглаж, хэн?, юу? хийж байгаа талаар ярилцана. - Үйл явдлын дарааллыг таамаглан дэвтэрт наахгүйгээр байрлуулна. “Эхлээд юу хийдэг вэ?”, “Дараа нь юу хийдэг вэ?”, “Эцэст нь юу хийдэг вэ?” гэсэн асуултаар багш чиглүүлж, зургийг дарааллын дагуу дэвтэрт наана. - Наасан зургаа “Би эхлээд .. хийдэг.”, “Дараа нь би ... хийдэг.” гэх мэт өөрийн хийдэг үйл дээр тулгуурлан танилцуулна. (1), (2)	- Найзын чинь байрлуулсан зураг чинийхээс юугаараа өөр байна вэ? - Хүн бүрийн өдрийн дэглэм адилхан байх уу? Яагаад?
---	--	---

Анхаарах зүйл


- Сурагчдын өдрийн дэглэм нь гэр бүл, амьдрах орчин, сургуульдаа ирэх, буцах нөхцөлөөс шалтгаалан ялгаатай байж болох тул нэг ижил дарааллыг заавал шаардахгүй.
- Энэ өдрийн дасгалаар сурагчдаар өдрийн дэглэмийг дарааллаар нь цээжлүүлэхээс илүү өөрийнхөө өдөр бүр тогтмол хийдэг дэглэмээ эргэн санах, үйл явдлын дарааллыг ойлгох, юу хийдгээ тайлбарлах үйлийг дэмжихэд чиглүүлнэ. Сурагчдын гэр бүлийн байдал, сургуульдаа ирэх, буцах зам, гэртээ хийдэг зүйл өөр, өөр байж болох тул сурагчийн хэлэх дарааллыг буруу гэж засахгүй байхад анхаарна.
- Зураг хайчилж, наах дасгалд аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах зааварчилгаа өгч хайчийг зөв барихыг өөрийн биеэр үзүүлнэ. Хайчлах үйлд удаан сурагчид урьдчилан хайчилж, бэлтгэсэн зураг өгөх, том хэмжээтэй бэлтгэсэн хувилбар ашиглуулах зэргээр оролцоог хангана.
- Хэл ярианы дэмжлэг шаардлагатай сурагчдад зураг зурах, зурагт картыг заах, дарааллаар байрлуулах, нэг үгээр хэлэх эсвэл үйл хөдөлгөөнөөр үзүүлж болно. Багш түүний илэрхийлснийг бүтэн өгүүлбэр болгон загварчилж давтан хэлж өгнө.
- Монгол хэлний өдөр тутам хийдэг үйл явдлынхаа дарааллыг ажиглаж, сонсож ойлгосноо өөрийн туршлагатай холбон ярих замаар сонсох, ярих чадвар; Математикийн суурь чадваруудыг дэмжинэ. Үүний зэрэгцээ хэрэглэгдэхүүнээ өөрөө сонгон бэлтгэх, ашигласныхаа дараа буцаан хураах, орчноо шалгаж цэгцлэх замаар бүтээлч үйл ажиллагааны болон суралцахуйд суралцах ерөнхий чадамжийг хөгжүүлэхэд чиглэнэ.

МИНИЙ ӨДРИЙН ДЭГЛЭМ

Өөрийнхөө өдрийн дэглэмийг найздаа яриарай.



Өөрт тустай үйлдлийг сонгоорой.



31



Хүүхэд зургуудыг ажиглаж, өглөөнөөс орой хүртэл өөрийн өдөр тутам хийдэг үйлүүдтэй холбон “Эхлээд..., дараа нь..., сүүлд нь...” гэх мэт дараалуулан ярилцана. Найзынхаа яриаг сонсож, зургаас өөрийн өдрийн дэглэм юугаараа ижил, юугаараа өөр байгааг анзаарна.

Хүүхэд зургуудыг харьцуулж, эрт унтах болон орой унтахын аль нь өөрт тустай болохыг сонгож, тэмдэглэнэ.

✓ Хичээл эхлэхэд бэлэн сууж буй хүүхдийг сонгоорой.



45 дугаар хуудсанд байгаа зургийг хайчилж, зөв дарааллаагаарай.



32

Сурагчдын царайны хувирал, ширээн дээрх эд зүйлсийг харьцуулан ажиглана. Аль хүүхэд хичээл хийхэд бэлэн байгааг сонгож, тэмдэглэнэ.

Үйл явдлыг дарааллын дагуу наана.

Өдөр тутмын үйл

Өглөө босох



Нүүр гараа
угаах



Өглөөний цай
уух



Сургууль руу
явах




Хичээл хийх



Орой унтах



Дарааллын тэмдэг



Эхлээд



Дараа нь



Эцэст нь

Үргэлжлүүлж ярья



Босох



Цайгаа уух



Сургууль явах

?

Үргэлжлүүлж ярья!

(4)

Махаар хийдэг бүтээгдэхүүн



Бууз



Банш



Хуушуур



Махан котлет



Хиам



Утсан мах



Борц



Махны фарш



Тефтель



Махан пирожки



Шорлог



Гуляш



Лаазалсан мах



Махны шөл



Махан пирог

СЭДЭВ 14. АШИГЛАЯ, ХУРААЯ

Өдрийн зорилго: Хичээл, хооллолтын үед ашигласан хэрэгслээ сонгон хэрэглэсний дараа байранд нь хурааж хэвшинэ.

Хэрэглэгдэхүүн: “Ашиглая, хураая” зурагт карт (1); эвлүүлдэг дүрс (2); савх, дүрс (3); хэрэглэгдэхүүний хураах сав (4); зурагт карт (5); зурагт карт (6); зурагт карт (7)

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт
I	Өнгийн харандаа, өнгийн цаас, цавуу, савх, дүрс гэх мэт хэрэглэгдэхүүнийг бодитоор үзүүлж, нэрлүүлж, юунд хэрэглэж болохыг ярилцана. (2), (3), (5), (6), (7) *Бүтээл тус бүрд хэрэгтэй хэрэгслийг холбоорой. - Дасгалыг ажиллахдаа багшийн чиглүүлэх асуултын дагуу ярилцана. - Хайчлах, наах, будах, зурах бүтээлийг тохирох хичээлийн хэрэгсэлтэй нь холбоно. - Яагаад хайч, харандаа, цавуу, өнгийн харандаатай холбосноо бусдад тайлбарлана. - Ангид байх хэрэглэгдэхүүнээс 1-ээс 2-ыг олуулж, хэрэглэсний дараа хаана буцааж тавих талаар ярилцана. “Авъя - Ашиглая - Хураая - Шалгая” дарааллыг зурагт картаар үзүүлж давтана. (1)	- Энэ бүтээлийг хийхийн тулд ямар үйлдэл хийх вэ? - Яагаад наана гэж бодсон бэ? - Яагаад хайчилна гэж бодсон бэ? - Яагаад зурна гэж бодсон бэ? - Яагаад будна гэж бодсон бэ? - Ямар хэрэглэгдэхүүн хэрэгтэй вэ? - Хэрэглэж дуусвал хаана буцааж тавих вэ?

II	* Хэрэгтэй зүйлээ сонгоход нь туслаарай. - Сурагчдыг “Эвлүүлж, хурааа” , “Зураад, хурааа”, “ Бүтээгээд, хурааа” гэсэн 3 багт хуваан, өртөөгөөр аялна. - Хэрэглэгдэхүүнийг багш урьдчилан сурагчийн тоогоор бэлтгэнэ. - Өртөө бүрийн эхэнд сурагчид хэрэгтэй хэрэглэгдэхүүнээ өөрсдөө сонгож авна. Багаараа хэрэглэгдэхүүнээ ээлжлэн хэрэглэнэ. - “Хураах” дохио өгөхөд хийж байгаа зүйлээ зогсоож, хэрэглэсэн зүйлээ зориулалтын сав, хайрцаг, буцаан хийж, ширээн дээр болон шалан дээр үлдсэн зүйл байгаа эсэхийг шалгана. Өртөө сэлгэхдээ авах, хураах, шалгах үүргийг сольж, сурагч бүр бүх үйлд оролцох боломжийг хангана. (3), (4) *Зөв дараалалд оруулаарай. - Өртөө сэлгэх тоглоомын дараа дасгал дээрх зургийг ажиглуулж, хэрэглэгдэхүүнээ авч байгаа, ашиглаж байгаа, буцаан хурааж байгаа үйлдлийг дарааллаар нь холбуулна. (1)	- Эхлээд юу хийх вэ? - Дараа нь юу хийж байна вэ? - Танай баг юу ашиглаж байна вэ? - Ашигласан хичээлийн хэрэгслээ хураасан уу? - Ширээн дээр юм үлдсэн үү? - Та нар юу ашигласан бэ? - Цэгцтэй хурааж чадсан уу?
III	Үдийн хоол (Үдийн хоолны цэс – мах, махан бүтээгдэхүүн) - Үдийн хоолонд орсон бүтээгдэхүүнийг нэрлэнэ. - Мах, махан бүтээгдэхүүний ач тусыг ярилцана.	- Аль хоолонд мах орсон байна вэ? - Мах идэх нь бидний биед ямар хэрэгтэй вэ?
IV	*Хичээлийн хэрэгслээ хураасан хүүхдийн зургийг олж, будаарай. - Зургийг ажиглаад, сурагч юу хийж байгааг ярилцана. - Хичээлийн хэрэгслээ цэгцэлж, байранд нь хурааж байгаа зургийг олж будна. *Хоосон нүдэнд байх хэрэгслийг зураарай. - Зургийн зүй тогтлыг ярилцаж, хоосон нүдэнд тохирох хэрэгслийг зурна.	- Аль зураг дээрх хүүхэд хичээлийн хэрэгслээ хурааж байна вэ? - Хоосон нүдэнд юу байх вэ?

Анхаарах зүйл:

- Сурагч зөвхөн зургийг дугаарлахгүйгээр бүтэн өгүүлбэрээр яриулахад анхаарна.
- Зүй тогтлыг ажиглаж, ижил ба ялгаатай шинжийг олж, тохирох зүйлийг сонгож зурна. Энэ дасгал нь сурагчийн ажиглах, харьцуулах, ангилах, дарааллын холбоог ойлгох, зүй тогтлыг илрүүлэх сэтгэлгээг хөгжүүлэхэд дэмжинэ.
- Өртөөт тоглоом болон дасгалын дэвтэр дээр сурагч бүр өөрийн боломж, хэрэгцээнд нийцүүлэн оролцохоор зохион байгуулна. Хөдөлгөөн, хараа, сонсгол, хэл яриа, анхаарал төвлөрөл болон суралцах үйлд дэмжлэг шаардлагатай сурагчид даалгаврыг заавал дуустал гүйцэтгэх шаардлагагүй. Зурагт зааврыг томруулж өгөх, үйлдлийг нэг нэг алхмаар үзүүлэх, хэрэглэгдэхүүний тоог цөөлөх, сонголтыг 2-3 болгон хялбарчлах, шаардлагатай тохиолдолд найзтай нь хослуулан ажиллуулах зэргээр дэмжинэ.

- Сурагч хэрэглэгдэхүүнийг өөрөө авч, зөөж байрлуулахад хүндрэлтэй бол заах, нэрлэх зэргээр оролцоог нь хангана. Хэл ярианы дэмжлэг шаардлагатай сурагч зураг заах, үйл хөдлөл ашиглах, нэг үгээр хэлэх, сонголтын карт ашиглах боломжийг олгоно.
- Сурагчийн өмнөөс нь хийж өгөхөөс аль болох зайлсхийж, өөрийн хийж чадах хэсгийг бие даан гүйцэтгэхэд нь хугацаа өгнө.
- Сурагчдыг гүйцэтгэх хурд, бүтээлийн чанар, их, бага хэмжээгээр хооронд нь харьцуулахгүй, хэрэглэгдэхүүнээ зориулалтын дагуу ашигласан, хамтран оролцсон, байранд нь буцаан хураасан зэрэг хувь хүний оролцоо, ахицад тулгуурлан урамшуулна.

АШИГЛАЯ, ХУРААЯ



Бүтээл бүрийг ажиглаж, түүнийг хийхэд ашигласан хэрэглэгдэхүүнийг ижил шинжээр нь таньж холбоно.



Тухайн бүтээлийг хийхэд тохирох хэрэглэгдэхүүнийг таньж, сонголтоо тайлбарлана.

33



Зураг дээрх хүүхдийн хийж буй үйлдлүүдийг ажиглаж, хэрэглэгдэхүүнээ авах-ашиглах-хураах дарааллыг тогтооно.




Зураг бүрийн үйлдлийг харьцуулж, хэрэглэгдэхүүнээ цэгцэлж, хурааж байгаа зургийг олж, будна.

Хичээлийн хэрэглэгдэхүүний давтагдсан дарааллыг ажиглаж, дараагийн юмсыг зурж гүйцээнэ.

34


(1)




(2)




(3)



(4)







Маргаашийн хичээлийг сурагчийн дэвтэрт ажиллахгүй, шагайгаар тоглох тул “сэдэв 15”-ийн багшийн зөвлөмжийг уншиж, хичээлийн бэлтгэлээ хангаарай.

СЭДЭВ 15. АЖИГЛАЯ, АНГИЛЪЯ, ТООЛЪЁ, ТОГЛОЁ

Өдрийн зорилго: Бодит зүйлсийг нэг шинжээр ангилах, 10 хүртэл тоолох, юмсын олон/цөөн харьцуулах үйлд оролцож, хамтран ажиллах, бусдын өмнүүр орохгүй байх, бусдыг хүндэлж ээлжээ хүлээх, хожих хожигдох байдлыг хүлээн зөвшөөрдөг болно.

Хэрэглэгдэхүүн: Тоглоомын дүрэм, 5 багт хүрэлцэх шагай, хивс олбог, шоо, туслах багш(багуудад тоглоомын дүрмийг танилцуулах, чиглүүлэх, тайлбарлах), шагайн суралцагчдад нийтэд нь харагдах макет, ижил ба ялгаатай шинжийг харуулан заах бодит зүйлсийг бэлтгэнэ.

Багаар ажиллах явцад сургуульд бэлтгэгдсэн байдлын оношлох үнэлгээ хийгдэнэ. Оношлох үнэлгээнд **Багшийн ажиглалтын хуудас №2** ашиглахыг анхаарна уу. Төлөвлөсөн үйл ажиллагааг өөрчлөхгүй хэрэгжүүлээрэй.

Цаг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт
I, II	- Сурагчдыг ижил сар/улиралд төрсөн, ижил өндөр, дуртай өнгө гэх мэтээр 5 багт хуваана. (суралцагчийн тооноос шалтгаална.) - Багууд юу хийх дарааллыг анхааралтай сонсоно. - Шагай няслах, морь уралдуулах, алаг мэлхий өрөх тоглоом тоглоно. (Тоглоом давхцаж болно) - Тоглоомын дүрэмтэй танилцана. - Багш 5 өртөө бэлтгэсэн байна. - Өртөө бүрд тоглоомын нэр, шагай, морь уралдахад хэрэглэх шоо бэлдсэн байна. - Сурагчдад тухтай байх дэвсгэр, олбог бэлдэнэ. - Сурагчдад биед эвтэйхэн хувцас өмсөж ирэхээр зохицуулна - Нэг өртөөнд хэт олон хүүхэд хуваагдахаас сэргийлнэ, хүүхэд бүр тоглохоор хуваагаарай. - Шагай шүүрэх өртөө нэмж болно. Шүүрэх шагайг аль болох жижиг цөөн шагай бэлтгэх, 1,2-оор шүүрч болох, хөө хуяг нь унавал шүүрсэнд тооцох гэх мэт насанд нь тохирсон уян хатан дүрэмтэйгээр тоглуулах. Шагай няслах тоглоомын дүрэм: - Нясалсан гараараа авахгүй - Ижил дүрсийг ижлээр нь нясалж хэн олон шагай авсан нь хожно гэх мэт Морь уралдуулах тоглоомын дүрэм: - Шагайгаа мориор өрөх - Өөрийн хамгийн сайн давхина гэж үзсэн шагайгаа сонгон авах, хаях шоогоо бэлдэнэ. Алаг мэлхий өрөх тоглоомын дүрэм: - Өнгө хамаарахгүй бэлтгэж өрсөн байна. - Шоо хаях тоогоор нэршлийг хэрэглүүлж хамгийн олон шагай цуглуулсан нь хожно. - Хэрэв 30-аас дээш суралцагчтай бол 5-6 баг болгох, хүүхэд бүр хойш суухгүй бүгд тоглоно. - Багшийн дохиогоор өртөөгөө солино.	- Чи хэнтэй баг болмоор байна вэ? - Чи хэдэн сард төрсөн бэ? хуруугаараа харуулаарай.

III	Багш зураг харуулж, ярилцана. (1) Сурагч бүр өөрийн хоолны хэрэгслээ үлдэгдлээс салгаж, цэвэрлэх, зориулалтын цүнх/уутанд хийх, цүнхэндээ зөв байрлуулах дарааллаар хийж, хэвшүүлнэ.	- Хоол идсэний дараа сав, аяга халбагаа хэрхэн авч явдаг вэ? - Хоолны үлдэгдэлтэй савыг шууд цүнхэндээ хийвэл юу болох вэ? - Хоолны үлдэгдлийг хаана, хэрхэн зөв хийх вэ? - Аяганы уут бохирдсон тохиолдолд яах вэ? - Цүнхний хаана нь хийвэл ном дэвтэр бохирдуулахгүй байх вэ?
IV, V	- “Хонь, ямаа”, “Морь, тэмээ” гэх мэт ижил төстэй, ялгаатай шинжээр нь жишээ авч тайлбарлана. - Тоглоомоо хурааж байхдаа өөрийн цуглуулсан шагайгаа багцаалж олон цөөнийг хэлнэ. - Багаараа цуглуулсан шагайгаа тоолцгооё. (тоолж чадахгүй байх магадгүй учраас багцаагаар олон цөөнийг хэлүүлэх) - - Өөрийн багт хэн, хэн байсныг нэрлүүлнэ. - Аль өртөөний тоглоом сонирхолтой байсан, яагаад гэдгээ тайлбарлана. - Бусдыг тоглож байхад үймүүлэхгүй, садаа болохгүй, хажуугаас оролцохгүй байна гэсэн дүрэм зохиож, мөрдүүлнэ. - Өртөөгөөр явж тоглосноо, багаар ажиллах ямар санагдсан тухай бусдадаа танилцуулна. - Өртөөгөөр тоглосон тоглоомоо гэрийнхэнтэйгээ хамт тоглохыг сануулаарай.	- Шагай няслах тоглоом дээр ямар хоёр шагайг нясалж байсан бэ? - Ижил шинжээр нь ялгах таних, ижилхэн ямар ямар дүрс байсан бэ? - Хонь, ямаа хоёрыг нясалж болох уу? - Морь буугаагүй байхад чи өөрийн морио давхиулсан уу? - Бусдын өмнүүр орсон уу, өөрийн дарааллаа хүлээсэн үү? - Шагай няслахад гар нь өвдсөн үү? - Энэ тоглоомоо гэрийнхэндээ зааж өгч чадах уу? - Тоглосон шагайгаа хураасан уу?

Анхаарах зүйл:

- Сурагч бүрийг тоглоомд тэгш оролцуулах, хүлээлгэхгүй байх.
- Тоглоомын дүрмийг насанд нь тохируулан ангийн, ойлгомжтой тайлбарлах.
- Шагайг няслах, шоо хаях үед аюулгүй байдлыг анхаарах.
- Бусдын өмнүүр орохгүй, ээлжээ хүлээх, бусдад саад болохгүй байхыг тогтмол сануулах.
- Хожих, хожигдохыг зөвөөр хүлээн зөвшөөрөх, сурагчдыг хооронд нь сайн, муугаар харьцуулахгүй байх.
- Тоолох чадвар харилцан адилгүй тул 10 хүртэл тоолуулахын зэрэгцээ олон, цөөн, ижил, ялгаатайг багцаалж хэлүүлэх.
- Өртөө солих үед багшийн дохио, зааврыг дагуулж, хүүхэд бүрийг бүх өртөөгөөр оролцуулах.
- Тоглоомын дараа хэрэглэсэн шагай, хэрэгслээ тоолж, хурааж, байранд нь тавиулах.

Багшийн ажиглалтын хуудас

(3-р долоо хоног, 15-р сэдэв, 2,4,5-р цаг)

Суралцагчийн нэр: Ажиглалт хийсэн багшийн нэр: Огноо:

Үнэлгээний зорилго: Суралцагчийн тоглоомын явцад заавар ойлгох, хамтран ажиллах, дүрэм баримтлах, математикийн үйлдлүүдийг бодит нөхцөлд хэрэглэх, санаа бодлоо илэрхийлэх чадварыг үнэлнэ.

№	Цаг	Шалгуур	Ажиглах үзүүлэлт	3	2	1
1	II	Заавар ойлгож дагах чадвар	Багшийн өгсөн зааврыг ойлгон үйл ажиллагаанд оролцсон.	☐	☐	☐
2		Багаар хамтран ажиллах чадвар	Багийн гишүүдтэйгээ хамтран тоглож, ээлжээ хүлээж, бусдын оролцоог хүндэтгэсэн.	☐	☐	☐
3		Дүрэм баримтлах чадвар	Өртөөний тоглоомын дүрмийг ойлгож, дүрмийн дагуу үйл ажиллагаанд оролцсон.	☐	☐	☐
4		Ээлжээ хүлээх чадвар, бусдыг сонсох чадвар	Өөрийн ээлжийг хүлээж, бусдын яриа болон үйл ажиллагааг анхааралтай сонсож хүлээсэн.	☐	☐	☐
5	IV	Тоолох, тооны ойлголтоо хэрэглэх чадвар	Шагайг зөв тоолж, олон-цөөн, их-багыг ялган тодорхойлоход оролцсон.	☐	☐	☐
6		Хэрэглэгдэхүүн ашиглах чадвар	Шагай, олбог гэх мэт болон хэрэглэсэн зүйлээ зөв хэрэглэж, эмх цэгцтэй хураасан.	☐	☐	☐
7	V	Өөрийн санаа бодлоо илэрхийлэх чадвар	Багшийн чиглүүлэг асуултын дагуу өөрийн оролцсон өртөөний тоглоомын талаарх сэтгэгдлээ илэрхийлсэн.	☐	☐	☐

Үнэлгээний тайлбар:

Заавар ойлгож дагах чадвар

- 3 - Зааврыг ойлгож, сануулгагүйгээр бие даан гүйцэтгэсэн
- 2 - Зааврыг ойлгох боловч дахин сануулга, чиглүүлэг шаардсан
- 1 - Зааврыг ойлгоход болон хэрэгжүүлэхэд байнгын тусламж авсан.

Багаар хамтран ажиллах чадвар

- 3 - Бусадтайгаа идэвхтэй хамтран ажиллаж, үүргээ гүйцэтгэсэн.
- 2 - Хамтран ажиллах боловч дахин чиглүүлэг шаардсан.
- 1 - Багаар ажиллахад хүндрэлтэй, байнгын дэмжлэг шаардсан.

Тоглоомын дүрэм мөрдөн оролцох чадвар

- 3 - Дүрмийг ойлгож, сануулгагүйгээр мөрдөн оролцсон.
- 2 - Дүрмийг мөрдөхдөө багшийн сануулга шаардсан.
- 1 - Дүрмийг ойлгох, мөрдөхөд байнгын тусламж шаардсан.

Ээлжээ хүлээх, бусдыг сонсох чадвар

- 3 - Ээлжээ тэвчээртэй хүлээж, бусдыг анхааралтай сонссон.
- 2 - Заримдаа сануулга өгснөөр ээлжээ хүлээсэн.
- 1 - Ээлжээ хүлээх, бусдыг сонсоход хүндрэлтэй байсан.

Тоолох, тооны ойлголтоо хэрэглэх чадвар

- 3 - Биет зүйлсийг зөв тоолж, олон-цөөн, их-багыг зөв ялгасан.
- 2 - Тоолох чадвартай боловч зарим алдаа гаргасан.
- 1 - Тоолох болон ялгахад ихээхэн дэмжлэг шаардсан.

Хэрэглэгдэхүүн ашиглах чадвар

- 3 - Хэрэглэгдэхүүнээ зөв ашиглаж, ажлын дараа байранд нь хураасан.
- 2 - Сануулга өгсөн тохиолдолд хэрэглэгдэхүүнээ зөв ашиглаж, хураасан.
- 1 - Хэрэглэгдэхүүнээ зөв ашиглах, хураахад дахин дэмжлэг авч багшийн тусламжтай хураасан..

Ээлжээ хүлээх, бусдыг сонсох чадвар

- 3 - Өөрийн бодол, сонголт, сэтгэгдлээ ойлгомжтой илэрхийлсэн
- 2 - Асуулт, тайлбарын тусламжтайгаар хариулсан.
- 1 - Санаа бодлоо илэрхийлэхэд хүндрэлтэй байсан.

Анхаарах зүйл:

- Хүүхдийг үйлдэл хийж байхад ямар нэгэн тусламж үзүүлэхгүй өөрөө оролдох боломж өгөх
- Хүүхдүүдийг харьцуулсан дүгнэлтийг хэлэхгүй байх
- Үйлдлийг гүйцэтгэх боломжит хугацааг өгөх, яаруулахгүй байх
- Зааврыг тодорхой өгөх, олон зааврыг нэг дор өгөхгүй байх

АЖИГЛАЛТЫН ХУУДСЫГ ОНООЖУУЛАХ АРГАЧЛАЛ

Ажиглах хуудасны үзүүлэлт бүрийг 3, 2, 1 гэсэн үнэлгээгээр тэмдэглэж, системд дараах байдлаар оноонд шилжүүлнэ.

- ✓ **3 үнэлгээ – 2 оноо:** Үйлдлийг бие даан, зөв гүйцэтгэсэн.
- ✓ **2 үнэлгээ – 1 оноо:** Үйлдлийг сануулга, чиглүүлэг, бага зэргийн тусламжтай гүйцэтгэсэн.
- ✓ **1 үнэлгээ – 0 оноо:** Үйлдлийг гүйцэтгэхэд байнгын тусламж, дэмжлэг шаардсан.

Ажиглалтын хуудасны тэмдэглэлийг дараах аргачлалын дагуу оноонд шилжүүлж системд шивнэ.

№	Цаг	Шалгуур	Ажиглах үзүүлэлт	3	2	1
1	II	Заавар ойлгож дагах чадвар	Багшийн өгсөн зааврыг ойлгон үйл ажиллагаанд оролцсон.	☐	☐	☐
2		Багаар хамтран ажиллах чадвар	Багийн гишүүдтэйгээ хамтран тоглож, ээлжээ хүлээж, бусдын оролцоог хүндэтгэсэн.	☐	☐	☐
3		Дүрэм баримтлах чадвар	Өртөөний тоглоомын дүрмийг ойлгож, дүрмийн дагуу үйл ажиллагаанд оролцсон.	☐	☐	☐
4		Ээлжээ хүлээх чадвар, бусдыг сонсох чадвар	Өөрийн ээлжийг хүлээж, бусдын яриа болон үйл ажиллагааг анхааралтай сонсож хүлээсэн.	☐	☐	☐



Багшийн ажиглалтын хуудасны тэмдэглэлийг оноонд шилжүүлэх аргачлал

№	Цаг	Шалгуур	Ажиглах үзүүлэлт	2 оноо	1 оноо	0 оноо
1	II	Заавар ойлгож дагах чадвар	Багшийн өгсөн зааврыг ойлгон үйл ажиллагаанд оролцсон.	☐	☐	☐

